



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ЗОРИУЛСАН
ЭРХ ЗҮЙН ГАРЫН АВЛАГА**



2018 оны 03 дугаар сар

Агуулга

А.Хууль, дүрэм, журам

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль	2
2. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль	4
3. Автотээврийн тухай хууль	5
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль	6
5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль	8
6. Гамшгаас хамгаалах тухай хууль	15
7. Галын аюулгүй байдлын тухай хууль	17
8. Хог хаягдлын тухай хууль	20
9. Төрийн хяналт шалгалтын тухай хууль	27
10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	28
11. Татварын ерөнхий хууль	33
12. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль	38
13. Зөрчлийн тухай хууль	38
14. Эрүүгийн хууль	45
15. Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам	48
16. Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам	55
17. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам	59
18. Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам	61
19. Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм	63
20. Гал түймрийн улсын хяналтын дүрэм	64

Б. Стандарт, норм, нормативын жагсаалт

1. Стандартуудын жагсаалт	66
2. Норм, нормативын жагсаалт	66

В. Иргэн, аж ахуйн нэгжид зориулсан мэдээлэл

1. Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн баримт бичгийн жагсаалт	67
2. Авто үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн мэдээлэл авах цахим хаягууд	68



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь бараа, бүтээгдэхүүн /цаашид “бараа” гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хэрэглэгч” гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг;

3.1.2.“худалдагч” гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид бараагаа борлуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг;

3.1.3.“үйлдвэрлэгч” гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид борлуулах зорилгоор бараа үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг;

3.1.4.“гүйцэтгэгч” гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид төлбөртэй болон төлбөргүй ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг;

3.1.5.“баталгаат хугацаа” гэж үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн бараа, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд гаргаж өгсөн хугацааг;

3.1.6.“ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх” гэж Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд тодорхойлсныг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ

5 дугаар зүйл.Чанар, аюулгүй байдлыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах хэрэглэгчийн эрх

5.1.Хэрэглэгч эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн нөхцөл, барилгын болон эрүүл ахуй, ариун цэврийн норм, фармакопей, жор, түүнчлэн хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлсон зохих чанар, тоо хэмжээ, аюулгүйн шаардлагыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах эрхтэй.

5.2.Хэрэглэгч баталгаат болон эдэлгээний хугацааны дотор барааны чанар, аюулгүй байдлаар хангагдах эрхтэй.

5.3.Хэрэв үйлдвэрлэгч удаан хугацаанд хэрэглэх бараанд баталгаат хугацаа тогтоогоогүй бол барааг худалдан авагчид шилжүүлсэн өдрөөс эхлэн хэрэглэгч хуульд өөрөөр заагаагүй бол 6 сарын хугацаанд барааны чанар, аюулгүй байдлын баталгаа авах эрхтэй.

5.4.Бараа, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаагүйгээс хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсны төлбөрийг Иргэний хуулийн арван найм, тавин хоёрдугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй.

6 дугаар зүйл.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх

6.2.Бараанд биет байдлын доголдол /тоо, хэмжээ, чанар, хугацаа/ болон эрхийн зөрчил илэрвэл хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд буюу хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй.

6.3.Хэрэглэгч согог гэмтэлтэй, иж бүрдэлгүй, тоо, хэмжээ, чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан худалдагчид Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу уг барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар дараахь шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй:

6.3.1.барааны доголдлыг үнэ төлбөргүй арилгуулах буюу уг доголдлыг хэрэглэгч өөрөөсөө болон гуравдагч этгээдээр арилгуулахад гаргасан зардлыг нөхөн төлүүлэх;

6.3.2.барааны үнийг доголдлын хэмжээтэй дүйцүүлэн бууруулах;

6.3.3.гэрээнд заасан тоо, хэмжээнээс дутуу барааг хүлээн авахаас татгалзах, эсхүл үнийг тооцож авах;

6.3.4.доголдолтой барааны оронд тухайн төрлийн доголдолгүй бараагаар солих, эсхүл барааг буцаан өгч, үнийг тооцож авах;

6.3.5.гэрээг цуцлах;

6.3.6.худалдагч нь барааны согог гэмтэл, иж бүрдлийн талаар урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд уг барааг хэрэглэгчийн шаардлагаар нэн даруй, ийм боломжгүй бол хэрэглэгчтэй тохиролцсон хугацаанд, эсхүл тухайн барааг буцаан эхний ээлжинд солих буюу иж бүрдүүлж өгөх. Хэрэв ийм боломжгүй болон хэрэглэгч шаардсан бол барааны үнэ, хөлсийг бүрнээр, эсхүл зөрүүг буцааж олгох;

6.3.7.баталгаат хугацааны дотор хэрэглэгчийн буруу биш шалтгаанаар тухайн бараа хэрэгцээ хангахгүй, нуугдмал согог гэмтэлтэй нь илэрвэл худалдагч түүнийг солих, эсхүл хэрэглэгчтэй тохиролцсон хугацаанд үнэ төлбөргүй засварлах. Хэрэв ийм боломжгүй болон хэрэглэгч шаардсан бол барааны үнэ хөлсийг бүрнээр, эсхүл зөрүүг буцааж олгох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ҮЙЛДВЭРЛЭГЧ, ХУДАЛДАГЧ, ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ

12 дугаар зүйл.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг

12.1.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд

болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулахгүй байх, заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байна.

12.2.Худалдагч барааг худалдаанд гаргахдаа үйлдвэрлэгч /нийлүүлэгч/-ээс энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан бараа нийлүүлэх талаар зохих гэрээг байгуулсан байна.

12.3.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч хэрэглэгчээс бараа, ажил, үйлчилгээний чанарын доголдлын талаар тавьсан шаардлагыг хуульд заасны дагуу барагдуулах үүрэг хүлээнэ.

12.8.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой худал мэдээлэл өгөхийг хориглоно.

13 дугаар зүйл.Барааны баталгаат хугацааг тогтоох үйлдвэрлэгч, гүйцэтгэгчийн үүрэг

13.1.Үйлдвэрлэгч, гүйцэтгэгч хуульд өөрөөр заагаагүй бол бараа, ажил, үйлчилгээний баталгаат хугацааг тогтооно.

13.2.Бараа, ажил, үйлчилгээг зах зээлд нийлүүлэхдээ түүнийг хэрэглэх заавар, хадгалах, тээвэрлэх, ашиглахад дагаж мөрдөх аюулгүйн зааварчилгаа, анхааруулга, үйлдвэрлэсэн он, сарыг худалдааны баримт бичиг, хаяг, шошго дээр хэрэглэгчид ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байхаар тусгана.

15 дугаар зүйл.Бараа, ажил, үйлчилгээний доголдлыг арилгах хугацаа

15.2.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр доголдлыг арилгах хугацаа хэтэрвэл хугацаа хэтэрсэн хоног тутам бараа, ажил, үйлчилгээний үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг худалдагч /үйлдвэрлэгч, гүйцэтгэгч/ хэрэглэгчид төлнө.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА

Ж.БЯМБАДОРЖ

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

2017 оны 12 дугаар сарын 21 өдөр

Энэ хуулийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “стандартчилал” гэж бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцан орлуулалт, мэдээлэл, техник, хэмжилт, сорилтын нэгдмэл, нийцтэй, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтээр, дахин давтан хэрэглэх журам тогтоох үйл ажиллагааг;

4.1.2. “стандарт” гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан, сонгон хэрэглэх баримт бичгийг;

4.1.3. “техникийн зохицуулалт” гэж бүтээгдэхүүний тодорхойлолт, боловсруулалт, үйлдвэрлэлийн арга, стандарт, техникийн үзүүлэлт болон шаардлагыг эш татаж, эсхүл тэдгээрийн агуулгыг тусгаж эрх бүхий байгууллагаас баталсан заавал дагаж мөрдөх баримт бичгийг;

4.1.4. “бүтээгдэхүүн” гэж үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцад бий болсон үр дүнг;

4.1.5. “тохирлын үнэлгээний итгэмжлэл” гэж эрх бүхий байгууллагаас тохирлын үнэлгээний байгууллага нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадвартайг тогтоож, хүлээн зөвшөөрөх ажиллагааг;

4.1.6. “тохирлын үнэлгээ” гэж бүтээгдэхүүн, ажилтны ур чадвар, менежментийн тогтолцоо нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох үйл ажиллагааг;

4.1.7. “тохирлын үнэлгээний байгууллага” гэж энэ хуулийн 4.1.6-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллагыг;

4.1.8. “нийлүүлэгчийн мэдэгдэл” гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа талаар үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчээс бичгээр гаргасан нотолгоог;

4.1.9. “аюулгүйн тэмдэг” гэж бүтээгдэхүүн нь техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагыг бүрэн хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээг;

4.1.10. “тохирлын баталгаа” гэж бүтээгдэхүүн нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгааг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.11. “тохирлын гэрчилгээ” гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцсэнийг тодорхойлсон баримт бичгийг.

4.2. Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад нэр томъёог Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр, олон улсын стандартын байгууллагын ISO/IEC 17000, түүний 2 дугаар аргачлалд заасны дагуу тус тус ойлгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ

13 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, хамрах хүрээ

13.1. Тохирлын үнэлгээний зорилго нь бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалахад оршино.

13.2. Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна.

13.4. Энэ хуулийн 13.2-т заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.

14 дүгээр зүйл.Тохирлын баталгаа

14.1.Тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна.

14.3.Тохирлын гэрчилгээг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага олгоно.

14.4.Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон улс орнуудад хүчин төгөлдөр байна.

14.6.Нийлүүлэгчийн мэдэгдэл нь энэ хуулийн 14.4-т заасан тохирлын гэрчилгээний нэгэн адил хүчин төгөлдөр байна.

14.7.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 14.2-т заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн, хүчин төгөлдөр аюулгүйн тэмдэгтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, экспортод гаргах, импортоор оруулахад хяналт, тохирлын үнэлгээнд давтан хамруулахгүй.

27 дугаар зүйл.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

27.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараахь эрхтэй:

27.1.1.бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлээр дэвшилтэт стандарт, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, тохирлын үнэлгээнд хамрагдах;

27.1.2.стандарт боловсруулахад оролцох;

27.1.3.стандарт, стандартчиллын хөтөлбөрийн төсөлд санал өгөх.

27.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний талаар дараахь үүрэгтэй:

27.2.1.стандарт, техникийн зохицуулалтад тогтоосон шаардлагын дагуу бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;

27.2.2.стандартыг боловсруулах, бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах, түүнтэй холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх;

27.2.3.стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний асуудлаар холбогдох дүрэм, журам, баримт бичиг боловсруулах чиглэлээр ажилтнаа чадавхижуулах.

27.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан стандартын төсөл нь хууль тогтоомж, техникийн зохицуулалт болон үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашигт харшлаагүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахааргүй байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД

31 дүгээр зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

31.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хэвлэх

32 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

32.1.Энэ хуулийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
М.ЭНХБОЛД

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."автотээврийн хэрэгсэл" гэж зорчигч, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, чиргүүл, цахилгаан тээврийн хэрэгслийг;

3.1.16."автотээврийн хэрэгслийн ашиглалт" гэж автотээврийн хэрэгслийг хадгалах, техникийн үйлчилгээ, засвар хийх, шатахуун тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, техникийн хяналтыг зохион байгуулж явуулах зэрэг автотээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн бүтэн байдал, найдварт ажиллагааг хангахад чиглэгдсэн техникийн ба зохион байгуулалтын арга хэмжээг;

3.1.18."авто үйлчилгээний байгууллага" гэж автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээг хэрэглэгчид үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг.

19² дугаар зүйл.Авто үйлчилгээний байгууллага

19².1.Авто үйлчилгээний байгууллага нь дараахь шаардлагыг хангаж ажиллана:

19².1.1.тухайн үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах;

19².1.2.тухайн үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхийг хэмжилзүйн мэргэжлийн байгууллагаар жил бүр шалгуулж, баталгаажуулах.

19².2.Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19².3.Авто үйлчилгээний байгууллага нь дараахь эрх, үүрэгтэй:

19².3.1.өөрийн ангилалд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах;

19².3.2.тухайн жилд үйлчлүүлсэн хэрэглэгчдийн талаарх судалгааг тогтоосон журмын дагуу автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх;

19².3.3.хэрэглэгчдэд үнэн бодит мэдээлэл өгөх;

19².3.4.авто үйлчилгээний ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байх;

19².3.5.авто үйлчилгээний бүтээгдэхүүний үнэ тарифыг тогтоох;

19².3.6.эрх бүхий байгууллагаар ангиллаа тогтоолгох.

19².4.Авто үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангасан иргэн авто үйлчилгээ эрхэлж болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."тээврийн хэрэгсэл" гэж хүн, ачаа, суурилагдсан тоног төхөөрөмжийг замаар тээвэрлэхэд зориулсан хэрэгслийг;

3.1.8."замын хөдөлгөөний аюулгүй байдал" гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг;

3.1.9."замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах" гэж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

10 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан

10.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан нь дараах төрөлжсөн сангаас бүрдэнэ:

10.1.1.тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд механикжсан тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, ашиглалт, засвар, оношилгооны бүртгэл, мэдээллийг хамруулах;

ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

13 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

13.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар иргэн, хуулийн этгээд дараах үүргийг хүлээнэ:

13.2.4.зам дээр болон түүний ойр орчимд ажил, үйлчилгээ хийхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;

13.2.5.замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх;

13.2.6.иргэн, хуулийн этгээд оршин байгаа газартаа хамаарах замын бохирдол, цас мөсийг цэвэрлэх;

13.2.8.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД БАРИМТЛАХ ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

21 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл, түүний хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх, угсрах, импортлоход тавих шаардлага

21.2.Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна.

21.3.Гадаад улсад ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.

23 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлага

23.1.Тээврийн хэрэгсэлд хийсэн техникийн үйлчилгээ, засвар тухайн тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд аюулгүй оролцох шаардлагыг бүрэн хангасан байвал зохино.

23.2.Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засварыг хийхдээ үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдлөг болгоно.

23.3.Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийх үйл ажиллагааг тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийх журмаар зохицуулна.

23.6.Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийсэн хуулийн этгээд тухайн тээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлт замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад бүрэн нийцэж байгааг зохих баримт бичгээр баталгаажуулсан байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД

55 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

55.1.Энэ хуулийг 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

З.ЭНХБОЛД

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2010 оны 7 дугаар сарын 08-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоож, гадаадын иргэн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суухтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

3.1.Энэ хуулийн заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, тус улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэн /цаашид "гадаадын иргэн" гэх/, гадаадын иргэнийг уригчид хамаарна.

3.2.Хуульд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэнд хамаарах энэ хуулийн зохицуулалт нь харьяалалгүй хүнд нэгэн адил үйлчилнэ.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан тугаар ойлгоно:

5.1.1.“гадаадын иргэн” гэж Монгол Улсын иргэний харьяалалгүй бөгөөд гадаад улсын иргэний харьяалалтай хүнийг;

5.1.2.“уригч” гэж гадаадын иргэнийг Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгааг гаргаж түүнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон тус улсад хууль ёсоор 90 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг;

5.1.3.“дамжин өнгөрөгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин нэг улсаас нөгөө улсад зорчиж байгаа гадаадын иргэнийг;

5.1.4.“түр ирэгч” гэж Монгол Улсад 90 хүртэл хоногийн хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг;

5.1.5.“хувийн хэргээр оршин суугч” гэж суралцах, хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, гэр бүлийн шалтгаан болон хувийн бусад ажлаар Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг;

5.1.6.“албан хэргээр оршин суугч” гэж төрийн байгууллагын урилгаар болон Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын эрх бүхий байгууллага, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллахаар Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг;

5.1.8.“цагаач” гэж Монгол Улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

5.1.10.“паспортыг орлох баримт бичиг” гэж Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр паспорттай адилтган үзэхээр хүлээн зөвшөөрсөн, тухайн хүнийг гадаад улсын иргэн болохыг гэрчилж байгаа баримт бичгийг;

5.1.11.“Монгол Улсын виз” гэж гадаадын иргэнд Монгол Улсын хилээр нэвтрэх эрх олгосон зөвшөөрлийн хуудсыг;

5.1.12.“визийн зөвшөөрөл” гэж гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт гадаадын иргэнд виз олгохыг зөвшөөрч олгосон баримт бичгийг;

7 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх, үүргийн онцлог

7.1.Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд гадаадын иргэний эрх, эрх чөлөөнд хуулиар хязгаарлалт тогтоож болно.

7.2.Гадаадын иргэн энэ хуулийн 7.1-д заасны дагуу хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний нэгэн адил эрх, эрх чөлөөг эдэлж, үүрэг хүлээнэ.

7.3. Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь эрхийг эдэлнэ:

7.3.1. энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсад нэвтрэх, оршин суух;

7.3.2. улсын онц чухал объектод Засгийн газрын зөвшөөрснөөр ажиллах;

7.3.3. улс төрийн орогнол хүсэх;

7.3.4. хууль тогтоомжид заасан бусад эрх.

7.4. Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь үүрэг хүлээнэ:

7.4.1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг сахин биелүүлж, Монголын ард түмний уламжлал, зан заншлыг хүндэтгэх;

7.4.2. энэ хуулийн 24, 26 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлэх;

7.4.3. Монгол Улсын хууль тогтоомжид заасан татвар төлөх;

7.4.4. Монгол Улсад зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсын виз, оршин суух зөвшөөрлийн хугацаанд байх, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хугацаандаа буюу эрх бүхий байгууллагын шаардсанаар тус улсаас гарах;

7.4.5. паспорт болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон оршин суух үнэмлэхийг биедээ авч явах;

7.4.6. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

8 дугаар зүйл. Гадаадын иргэнд хориглох зүйл

8.1. Гадаадын иргэнд Монгол Улсын нутаг дэвсгэрт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ Монгол Улсын эрх ашиг, тус улсын иргэний болон бусад хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд харш үйлдэл хийх;

8.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох;

8.1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулах;

8.1.4. тус улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодисыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглэх;

8.1.5. хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр зөвшөөрөлтэй эрхлэхээр заасан үйл ажиллагааг зөвшөөрөлгүй явуулах;

8.1.6. Монгол Улсын виз, оршин суух, бүртгүүлэх журам зөрчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэх, шилжин суурьших;

8.1.7. хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа.

10 дугаар зүйл. Гадаадын иргэнийг уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг

10.1. Гадаадын иргэнийг Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

10.1.1. гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагад бүртгүүлэх;

10.1.2. гадаадын иргэн Монгол Улсад оршин суухад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаа гаргах;

10.1.3. Монгол улсын виз, оршин суух зөвшөөрлийнх нь хугацаанд гадаадын иргэнийг буцаах.

10.2. Энэ хуулийн 10.1.2-т заасан баталгааны төрөл, хэлбэр, тэдгээрийг мэдүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 9.2.2-т заасан журмаар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ВИЗ

11 дүгээр зүйл.Монгол Улсын виз

11.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад нэвтрэх гадаадын иргэн Монгол Улсын виз (цаашид “виз” гэх)-ийг зохих журмын дагуу авсан байна.

11.2.Визийг хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичигтэй гадаадын иргэнд олгоно.

11.3.Визийг хавсралт хуудсаар олгож болно.

11.4.Виз нь дипломат, албан, энгийн гэсэн зэрэгтэй байна.

11.5.Виз нь орох, гарах-орох, дамжин өнгөрөх зориулалттай, Монгол Улсын хилээр нэвтрэх зорилгыг агуулсан ангилалтай, нэг, хоёр, олон удаагийн гэсэн төрөлтэй байна.

11.6.Гадаадын иргэн виз авсан нь түүнийг Монгол Улсад нэвтрүүлэх баталгаа болохгүй.

11.7.Визийн загварыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

14.2.Энгийн зэргийн визийг визийн хуудсан дээр “Е” гэсэн латин үсгээр ялгаж тэмдэглэнэ.

15 дугаар зүйл.Визийн ангилал

15.1.Тухайн гадаадын иргэний хилээр нэвтрэх зорилгыг үндэслэн дараахь ангиллын виз олгоно:

15.1.1.“D” ангиллын визийг энэ хуулийн 12.1-д заасан гадаадын иргэнд;

15.1.2.“A” ангиллын визийг энэ хуулийн 13.1-д заасан гадаадын иргэнд;

15.1.3.“T” ангиллын визийг гадаадын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, түүний салбар, төлөөлөгчийн газарт ажиллах удирдах албан тушаалтанд;

15.1.4.“O” ангиллын визийг төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын шугамаар ирэх гадаадын иргэнд;

15.1.5.“B” ангиллын визийг ажил хэргийн шугамаар ирэх гадаадын иргэнд;

15.1.6.“S” ангиллын визийг суралцах, мэргэжил дээшлүүлэх болон дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний байгууллага болон инновацийн салбарын гарааны компанид эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөдөлмөрийн гэрээгээр хийх зорилгоор ирэх гадаадын иргэнд;

15.1.7.“J” ангиллын визийг тус улсад жуулчлахаар ирэх гадаадын иргэнд паспортын төрлийг үл харгалзан;

15.1.8.“HG” ангиллын визийг тус улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах гадаадын иргэнд паспортын төрлийг үл харгалзан;

15.1.9.“SH” ангиллын визийг шашны байгууллагын шугамаар ирэх, оршин суух гадаадын иргэнд паспортын төрлийг үл харгалзан;

15.1.10.“TS” ангиллын визийг Монгол Улсад цагаачлах зөвшөөрөл авсан гадаадын иргэнд;

15.1.11.“H” ангиллын визийг Монгол Улсад хувийн хэргээр оршин суугчийн гэр бүлийн гишүүн болон хувийн урилгаар ирэх гадаадын иргэнд паспортын төрлийг үл харгалзан.

16 дугаар зүйл.Виз олгох байгууллага

16.1.Визийг дараахь байгууллага олгоно:

16.1.1.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

16.1.2. гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

16.1.3.гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсын өргөмжит консул.

18 дугаар зүйл.Визийн хүчинтэй байх хугацаа

18.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нэг удаагийн орох виз нь гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтрэх хүртэл 90 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

18.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол түр ирэгчид олгох олон удаагийн визийн хүчинтэй байх хугацаа нь 183 буюу

365 хоног байх бөгөөд түр ирэгчийн Монгол Улсад байх хугацаа нь 30 хоног байна.

18.3. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгох олон удаагийн визийн хүчинтэй байх хугацаа нь оршин суух зөвшөөрлийн хугацаагаар тодорхойлогдоно.

18.4. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд олгосон гарах-орох визийн хүчинтэй байх хугацаа нь Монгол Улсаас гарснаас хойш 180 хүртэл хоног хүчинтэй байна.

18.5. Визийн хуудсан дээр түүний хүчинтэй байх хугацааг нь он, сар, өдөр гэсэн дарааллаар зааж тэмдэглэнэ.

19 дүгээр зүйл. Монгол Улсад байх хугацааг визээр тодорхойлох

19.1. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын иргэн Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш тус улсад байх хугацааг дор дурдсанаар тодорхойлж визэнд заана:

19.1.1. түр ирэгч 90 хүртэл хоног;

19.1.2. дамжин өнгөрөгч 10 хүртэл хоног;

19.1.3. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд хугацаагүйгээр буюу оршин суух зөвшөөрөл олгох хүртэл.

19.2. Энэ хуулийн 19.1.1-д заасан хугацааг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

20 дугаар зүйл. Виз, визийн зөвшөөрөл

20.1. Виз, визийн зөвшөөрлийг уригчийн хүсэлт, энэ хуулийн 10.1.2-т заасан баталгааг харгалзан олгоно.

20.2. Уригч нь гадаадын иргэнд дипломат, албан зэргийн виз олгуулах хүсэлтийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, энгийн зэргийн виз олгуулах хүсэлтийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус гаргана.

20.3. Энэ хуулийн 16.1-д заасан виз олгох байгууллага нь Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух хүсэлт гаргасан гадаадын

иргэнд виз олгох эсэхийг шийдвэрлэхдээ эрүүл мэндийн шинжилгээ хийлгэхийг шаардаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ГАДААДЫН ИРГЭН МОНГОЛ УЛСАД ОРШИН СУУХ

24 дүгээр зүйл. Гадаадын иргэнийг бүртгэх

24.1. Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч болон энэ хуулийн 32.2-т заасан гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

24.2. Гадаадын иргэнийг урьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүнийг бүртгүүлэх үүргийг хүлээнэ.

24.3. Энэ хуулийн 24.2-т зааснаас бусад тохиолдолд гадаадын иргэн өөрөө бүртгүүлнэ.

24.4. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улс, олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.

25 дугаар зүйл. Гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэл

25.1. Гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба эрхлэн явуулж, холбогдох мэдээллийг сар бүр гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

26 дугаар зүйл. Гадаадын иргэний хаягийн бүртгэл

26.1. Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасан оршин суугч гадаадын иргэн 14 хоногийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад хаягийн бүртгэл хийлгэнэ.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан гадаадын иргэн оршин суугаа хаягаа өөрчилбөл анх бүртгүүлсэн газартаа мэдэгдэн хасалт хийлгэж,

шилжин очсон сумын Засаг даргын Тамгын газарт, эсхүл хорооны Засаг даргад 14 хоногийн дотор хаягийн бүртгэл хийлгэнэ.

27 дугаар зүйл.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух

27.1.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг гадаадын иргэний хүсэлт, холбогдох байгууллагын санал, зөвшөөрлийг харгалзан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 5 хүртэл жилээр олгож, тухай бүр 3 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.

27.2.Гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг дараахь хэлбэрээр олгоно:

27.2.1.гэр бүлийн шалтгаанаар;

27.2.2.цагаачлах;

27.2.3.хөдөлмөр эрхлэх;

27.2.4.хөрөнгө оруулах;

27.2.5.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болон хувийн бусад зорилгоор.

27.3.Дараахь тохиолдолд гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгохоос болон уг зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгож болно:

27.3.1.тагнуул, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн;

27.3.2.энэ хуульд заасан виз, бүртгэл, оршин суух журмыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн;

27.3.3.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулсан.

27.3.4.виз, эрх бүхий байгууллагаас олгодог аливаа зөвшөөрөл, баримт бичгийг засварласан, хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн.

28 дугаар зүйл.Монгол Улсад гэр бүлийн шалтгаанаар оршин суух

28.1.Монгол Улсын иргэнтэй гэр бүл болж гэрлэлтээ бүртгүүлсэн, түүнчлэн хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэний эхнэр, нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд нь тус улсад оршин суух хүсэлт гаргавал гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага тэдгээрт Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг энэ хуулийн 27.1-д заасан хугацаагаар олгоно.

28.2.Энэ хуулийн 27.2.3-27.2.5-д заасан гадаадын иргэний Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн хугацаагаар түүний гэр бүлийн гишүүний тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа тодорхойлогдоно.

28.4.Энэ хуулийн 27.3-т зааснаас гадна дараахь тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадын иргэнд Монгол Улсад гэр бүлийн шалтгаанаар оршин суух зөвшөөрөл олгохоос болон зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзах буюу хүчингүй болгоно:

28.4.1.энэ хуулийн 28.1-д заасан зөвшөөрлийг авах зорилгоор Монгол Улсын иргэнтэй хуурамчаар гэр бүл болсон;

28.4.2.Гэр бүлийн тухай хуулийн 11.2-т заасны дагуу гэрлэлт дуусгавар болсон.

29 дүгээр зүйл.Монгол Улсад цагаачлах

29.1.Монгол Улсад цагаачлах эрх авах тухай гадаадын иргэний хүсэлт, улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж, цагаачлах хүсэлтэй хүний боловсрол, мэргэжлийг харгалзан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрлийг энэ хуулийн 27.1-д заасан хугацаагаар олгоно.

29.3.Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн жилд 180 хоногоос дээш хугацаагаар тус улсын нутаг дэвсгэрт байгаагүй бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь цагаачлах зөвшөөрлийг хүчингүй болгож болно.

29.4.Монгол Улсад цагаачлан амьдрах оршин суух зөвшөөрөл авсан харьяалалгүй хүн гадаадад зорчих бол гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүнд гадаадад зорчих үнэмлэх олгоно.

30 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулах, суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор Монгол Улсад оршин суух

30.1.Хөрөнгө оруулах, хөдөлмөр эрхлэх, суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх зорилгоор Монгол Улсад ирсэн гадаадын иргэнд хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлт, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тэдгээрийн эрх олгосон байгууллагын хүсэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага оршин суух зөвшөөрөл олгоно.

30.2.Гадаадын иргэн нь энэ хуулийн 30.1-д заасан зөвшөөрлийн хугацааг дуусахаас өмнө холбогдох байгууллагын хүсэлтийг авч гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж оршин суух хугацааг сунгуулна.

31 дүгээр зүйл.Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг хянан шийдвэрлэх хугацаа

31.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг 60 хоногийн дотор, уг зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

32 дугаар зүйл.Монгол Улсад албан хэргээр оршин суух

32.1.Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн болон гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус улсад оршин суух зөвшөөрөл олгож, хугацааг нь сунгана.

32.2.Төрийн байгууллагын урилгаар ирсэн болон Засгийн газар хоорондын байгууллагад ажиллах гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, хугацааг нь сунгах асуудлыг уригч байгууллагын хүсэлтийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

33 дугаар зүйл.Гадаадын иргэнд үнэмлэх олгох

33.1.Монгол Улсад хувийн хэргээр болон энэ хуулийн 32.2-т заасны дагуу оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Монгол Улсад оршин суух үнэмлэх олгоно.

33.2. Энэ хуулийн 33.1-д заасан оршин суух үнэмлэхэд дараахь мэдээллийг тусгана:

- 33.2.1.овог нэр;
- 33.2.2.төрсөн он, сар, өдөр;
- 33.2.3.хүйс;
- 33.2.4.оршин суух үнэмлэхийн дугаар;
- 33.2.5.түүний 16 насанд хүрээгүй хүүхэд;
- 33.2.6.иргэний харьяалал;
- 33.2.7.оршин суух зөвшөөрлийн төрөл;
- 33.2.8.оршин суух зөвшөөрлийн цуврал дугаар;
- 33.2.9.олгосон байгууллага;
- 33.2.10.хүчинтэй үргэлжлэх хугацаа;
- 33.2.11.сунгалт;
- 33.2.12.регистрийн дугаар;
- 33.2.13.зөрчлийн тэмдэглэл;
- 33.2.14.байнга оршин суух хаяг, түүний өөрчлөлт;
- 33.2.15.гарын хурууны хээ.

33.3.Гадаадын иргэн Монгол Улсаас бүр мөсөн явах тохиолдолд оршин суух үнэмлэхээ гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хураалгана.

ДОЛДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСААС ГАРАХ

34 дүгээр зүйл.Монгол Улсаас гарах, гарахыг түдгэлзүүлэх

34.1.Гадаадын иргэн Монгол Улсад байхыг зөвшөөрсөн хугацаанд багтаж тус улсаас гарна.

34.2.Дараахь үндэслэл байвал гадаадын иргэнийг дор дурдсан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ:

34.2.1.гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл;

34.2.2.шүүхээр ял шийтгүүлсэн бол ялаа эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэх хүртэл;

34.2.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол.

35 дугаар зүйл. Монгол Улсаас гарахыг сануулах

35.1. Энэ хуулийн 27.3-т заасан үндэслэлээр оршин суух зөвшөөрөл олгоогүй, эсхүл урьд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан бол Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус улсаас сайн дураараа гарахыг гадаадын иргэнд сануулна.

35.2. Энэ хуулийн 35.1-д заасан сануулга авсан гадаадын иргэн 10 хоногийн дотор Монгол Улсаас гарах үүрэгтэй.

36 дугаар зүйл. Гадаадын иргэнийг саатуулах

36.1. Дор дурдсан үндэслэл байвал гадаадын иргэнийг саатуулж болно:

36.1.1. энэ хуулийн 35.2-т заасан хугацаанд гараагүй бол;

36.1.2. албадан гаргах ажиллагаанд саад учруулж, эсхүл гэмт хэрэг үйлдэж, зөрчил гаргаж болзошгүй бол;

36.1.3. паспорт буюу паспортыг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа бол.

36.2. Энэ хуулийн 36.1.3-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэнийг мөн хуулийн 41.1-д заасан гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулж болно.

36.3. Энэ хуулийн 36.1-д заасан үндэслэлээр гадаадын иргэнийг шүүхийн шийдвэрээр 14 хүртэл хоногийн хугацаагаар саатуулж болох ба шаардлагатай тохиолдолд гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

36.4. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гадаадын иргэнийг саатуулахад гарсан зардлыг өөрөөр

нь, эсхүл энэ хуулийн 10.1.2–т заасан баталгаа гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагаар төлүүлж болно.

36.5. Энэ хуулийн 36.1.1, 36.1.3-т заасан зөрчил гаргасан гадаадын иргэнийг тодорхой барьцаатайгаар саатуулахгүй байж болно.

37 дугаар зүйл. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах

37.1. Гадаадын иргэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал дараахь үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргана:

37.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр бус буюу хуурамч баримт бичгээр нэвтэрсэн нь нотлогдсон;

37.1.2. оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн;

37.1.3. түр ирэгч нь виз, бүртгэлийн журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн;

37.1.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;

37.1.5. Сэтгэцийн өвчтэй болохыг нь эрүүл мэндийн байгууллага тогтоосон;

37.1.6. хуурамч баримт бичиг ашиглаж виз, оршин суух зөвшөөрөл авсан, эсхүл виз, оршин суух зөвшөөрлийг засварласан буюу хуурамчаар үйлдсэн;

37.1.7. эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан;

37.1.8. энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсаас сайн дураараа гарах сануулгыг биелүүлээгүй;

37.1.9. нийгмийн хэв журмыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан гадаадын иргэний талаар цагдаагийн байгууллагаас үндэслэл бүхий санал ирүүлсэн;

37.1.10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй этгээд гэж холбогдох байгууллагаас үзсэн;

37.1.11.шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон;

37.1.12.түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

42 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

42.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

44.1.Энэ хуулийг 2010 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2017 оны 2 дугаар сарын 02-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон

нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

4.1.3.“осол” гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг;

4.1.4.“гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг;

4.1.5.“аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг;

4.1.7.“гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхийг;

4.1.8.“гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа” гэж гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.18.“сайн дурын хэсэг” гэж сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГАМШГИЙН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа

6.1.Гамшгийн өмнөх үйл ажиллагаа нь дараахь төрөлтэй байна:

- 6.1.1.гамшгийн эрсдэлийг үнэлэх;
- 6.1.2.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх;
- 6.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах;
- 6.1.4.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах;
- 6.1.5.гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх;
- 6.1.6.гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах;
- 6.1.7.гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх.

7 дугаар зүйл. Гамшгийн эрсдэлийг үнэлэх

7.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.

7.2.Гамшгийн эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 7.3-т заасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.

7.6.Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг энэ хуулийн 7.1-д заасан байгууллага өөрөө хариуцна.

8 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх

8.1.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.

8.2.Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

9 дүгээр зүйл. Гамшгийн эрсдэлийг бууруулах

9.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор энэ хуулийн 8.1-д заасан байгууллага, хуулийн этгээд дараахь арга хэмжээг авна:

9.1.1.болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг арилгах;

9.1.2.барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг улс, орон нутгийн төсөвт байгууллага, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах;

9.1.3.гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.1.4.гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх;

9.1.5.хөгжлийн бодлогын төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг

тооцох.

10 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

10.1.Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь гамшгаас хамгаалах бэлэн байдлын дараахь зэрэгтэй байна:

10.1.1.өдөр тутмын бэлэн байдал;

10.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал;

10.1.3.бүх нийтийн бэлэн байдал.

10.3.Өдөр тутмын бэлэн байдлын үед дараахь арга хэмжээг авна:

10.3.1.нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах;

10.3.2.харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах;

10.3.3.гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

10.3.4.гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх;

10.3.5.гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх;

10.3.6.гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах..

13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах

13.3.Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь байгууллага, албан тушаалтан зохион байгуулна:

13.3.7.хуулийн этгээдийн ажилтны сургалтыг тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан.

13.4.Энэ зүйлийн 13.3.1-д заасан сургалтыг 2 жилд нэг удаа, 13.3.2, 13.3.3, 13.3.4, 13.3.5, 13.3.7-д заасан сургалтыг жил бүр зохион байгуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

34 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн эрх, үүрэг

34.2.Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

34.2.1.гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;

34.2.2.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

34.2.3.үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;

34.2.4.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах;

34.2.5.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;

34.2.8.гамшиг болон аюулын үед өөрийн байгууллагын хэрэгцээнд ашиглах барилга байгууламж, хоргодох байрыг төхөөрөмжлөх, шаардлагатай тохиолдолд хүн амд ашиглуулах;

34.2.9.гамшгийн үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх.

34.2.10.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөний улмаас гарсан зардлыг хариуцах.

37 дугаар зүйл. Иргэний эрх, үүрэг

37.2.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараахь үүрэг хүлээнэ:

37.2.1.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

37.2.2.гамшгаас хамгаалах сургалтад оролцох;

37.2.3.өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах;

37.2.4.гамшиг болон аюулаас урьдчилан сэргийлэх, аврах арга, техник, багаж хэрэгслийг эзэмших, зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх;

37.2.5.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох;

37.2.6.гамшиг болон аюулын тухай мэдээллийг холбогдох байгууллагад шуурхай, үнэн зөв хүргэх;

37.2.7.эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг зөрчсөний улмаас гарсан зардлыг хариуцах.

АРАВДУГААР БҮЛЭГ

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

51.2.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

52 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

52.1.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

М.ЭНХБОЛД

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“гал түймэр” гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг;

3.1.2.“гал түймэр унтраах” гэж гал түймрийн үед хүний амь насыг аврах, гал түймрийг унтраахын тулд тодорхой хүн хүч, техник хэрэгслээр тохирсон арга, хэлбэрийг ашиглан гүйцэтгэх үйл ажиллагааг;

3.1.4.“галын аюулгүй байдал” гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг;

3.1.5.“гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж” гэж барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамж, хүн нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслийг;

3.1.10.“гал түймрийн аюулын үнэлгээ” гэж барилга байгууламжийн ангилал, зураг төсөл, хийц, бүтээц, үйлдвэрлэлийн технологи, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт нь норм, нормативын шаардлагад нийцэж байгаа эсэх, гал түймрээс учирч болзошгүй хохирлын хэмжээг тодорхойлж үнэлэхийг;

3.1.11.“гал түймрээс хамгаалах үйлчилгээ” гэж гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, гал түймрээс хамгаалах нэмэлт арга хэмжээ авах, гал түймэртэй тэмцэх хэсэг, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хяналтын нэгж ажиллуулахыг;

3.1.12.“галын аюултай бүтээгдэхүүн” гэж галын эх үүсвэрээс болон химийн урвалын үйлчлэлээр хялбар авалцан асах, хорт хий, утаа ялгаруулах, тэсэрч дэлбэрэх аюултай бодис, материалыг;

7 дугаар зүйл. Гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

7.1. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа явуулах чиг үүргийг аймаг, нийслэлийн онцгой байдлын байгууллага төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл. Гал түймэртэй тэмцэх хэсэг

13.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн болон бусдын өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор гал түймэртэй тэмцэх хэсэгтэй байж болно.

13.2. Гал түймэртэй тэмцэх хэсэг тогтоосон нутаг дэвсгэр, аж ахуйн нэгжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд уг хэсгийн ажиллах

журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, батална.

13.3. Гал түймэртэй тэмцэх хэсэг тогтоосон нутаг дэвсгэр, аж ахуйн нэгжийн хүрээнд гарсан гал түймрийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

16 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаарх иргэний эрх, үүрэг

16.2. Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараах үүрэг хүлээнэ:

16.2.1. ахуйн галын аюулгүй байдлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг сахин биелүүлэх;

16.2.2. гал түймэр гарч байгаа тохиолдолд онцгой байдлын байгууллагад нэн даруй мэдэгдэх;

16.2.3. гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

16.2.4. гал түймэр гарч болзошгүй зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх;

17 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

17.2. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дараах үүрэг хүлээнэ:

17.2.1. холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилох;

17.2.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах;

17.2.3.барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах;

17.2.4.ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

17.2.5.гал түймэр унтраах үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

17.2.6.гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангах;

17.2.7.барилга байгууламж, үйлдвэрийн технологид хэрэглэх бодис, материалын гал түймрийн аюулын зэрэглэлийг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулах;

17.2.8.гал түймрийн улмаас аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлын хэмжээг эрх бүхий үнэлгээний байгууллагаар тогтоолгох;

17.2.9.гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу хийлгэх;

17.2.10.галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах;

17.2.11.галын аюулгүй байдлыг хангах талаар байгууллагын хэмжээнд галын сайн дурын бүлгэм ажиллуулах.

17.3.Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэлтэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

18 дугаар зүйл.Галын аюулгүй байдлыг хангах үндэслэл

18.3.Барилга байгууламж, гэр хорооллыг гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай, гал түймэр унтраах үед ашиглах усан хангамжтай байхаар төлөвлөнө.

18.5.Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс

хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдалд гал түймрийн аюулын үнэлгээ хийлгэнэ.

19 дүгээр зүйл.Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих нийтлэг шаардлага

19.1.Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна.

19.3.Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл гал түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангагдсан байна. Анхан шатны багаж, хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

19.4.Барилга байгууламж галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан гал түймрээс хамгаалах автомат тоног төхөөрөмжтэй байна.

19.5.Аж ахуйн нэгж, байгууллага гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, ажилтнаа сургаж, дадлагажуулсан байна.

20 дугаар зүйл.Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг

20.1.Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийг албан тушаалтан, иргэн үйл ажиллагаандаа удирдлага болгон дагаж мөрдөх үүрэгтэй.

21 дүгээр зүйл.Барилга байгууламж, объектын зураг төсөл зохиох, хянахад галын аюулгүй байдлыг хангах шаардлага

21.3.Галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх талаар магадлал хийгдээгүй зураг төслөөр барилга байгууламж барих, галын аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга байгууламж ашиглахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

З.ЭНХБОЛД

ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар дараахь хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна:

3.1.1.энгийн хатуу хог хаягдал;

3.1.2.цацраг идэвхт хог хаягдлаас бусад хий, шингэн, хатуу төлөвт орших аюултай хог хаягдал.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“**хог хаягдал**” гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг;

4.1.2.“**аюултай хог хаягдал**” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;

4.1.7.“хог хаягдал ангилах” гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгахыг;

4.1.8.“хог хаягдал цуглуулах” гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэхийг;

4.1.9.“хог хаягдал хадгалах” гэж байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулахыг;

4.1.20.“хог хаягдлыг устгах” гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфиллд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалахыг;

4.1.21.“хог хаягдал шатаах зориулалтын байгууламж” гэж хог хаягдлыг өндөр хэмд, хяналттай шатаах төхөөрөмж бүхий байгууламжийг;

4.1.22.“ландфилл” гэж хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламжийг;

4.1.23.“хог хаягдлын төвлөрсөн цэг” гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газрыг;

4.1.24.“аюултай хог хаягдлын дагалдах бичиг” гэж батлагдсан журмын дагуу бөглөж, гарын үсэг зурж, баталгаажуулсан тээврийн баримт бичгийг;

4.1.32.“аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс” гэж аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, хадгалах, устгахад шаардагдах зардлын мөнгөн дүнг;

4.1.33.“хог хаягдлыг ил шатаах” гэж хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус байгууламжид шатаахыг;

4.1.36.“**тээврийн хэрэгслийн хог хаягдал**” гэж тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ болон ашиглалтаас гарсан тээврийн хэрэгсэл, тэдгээрийг задлахад үүсэх хог хаягдлыг;

4.1.38.“аюултай хог хаягдал үүсгэгч” гэж үйл ажиллагаа болон үйлдвэрлэлээс нь аюултай хог хаягдал үүсдэг аж ахуйн нэгж, байгууллагыг;

4.1.39. “аюултай хог хаягдал хүлээн авагч” гэж аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг;

4.1.40. “аюултай хог хаягдал тээвэрлэгч” гэж аюултай хог хаягдлыг үүсгэгч болон өмчлөгчөөс тээврийн хэрэгслээр хүлээн авагчид хүргэх үйл ажиллагаа эрхлэгчийг;

4.1.41. “аюултай хог хаягдал хариуцсан ажилтан” гэж хэвийн болон аюул, осол гарсан үед аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажилтныг;

4.1.44. “аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюултай хог хаягдал асгарах, алдагдах болон тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах, хэрэгжүүлэх, зохицуулах арга хэмжээг төлөвлөж, тодорхойлсон баримт бичгийг;

4.1.45. “онцгой байдлын зохицуулагч” гэж аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах ажилтныг;

4.1.46. “аюултай хог хаягдал алдагдах” гэж аюул, ослын үед аюултай хог хаягдал хөрс, ус руу асгарах, алдагдах, эсвэл зориудаар аюултай хог хаягдлыг хөрс, ус руу хаях, асгах, нийлүүлэх, шахах, ялгаруулахыг;

4.1.51. “шүүрэл” гэж аюултай хог хаягдлаас ялгарсан шингэнийг;

5 дугаар зүйл. Хог хаягдлыг өмчлөх эрх

5.1. Хог хаягдлыг үүсгэгч этгээд өмчлөх эрхтэй.

5.2. Хог хаягдлыг өмчлөх эрх гэрээний үндсэн дээр шилжиж болно.

5.3. Хог хаягдлыг зориулалтын цэгт байршуулснаар өмчлөх эрх дуусгавар болно.

5.4. Энэ хуулийн 5.2, 5.3-т заасны дагуу өмчлөх эрх шилжсэнээр хог хаягдлыг өмчлөх тухайн этгээдийн эрх дуусгавар болж, хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, хадгалах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөх эрх үүснэ.

5.5. Аюултай хог хаягдлыг өмчлөгч нь өмчлөх эрхээ шилжүүлсэн бол энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, аюултай хог хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлнэ:

10.1.1. хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;

10.1.2. хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.

10.2. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

10.2.1. энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;

10.2.2. энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;

10.2.3. аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;

10.2.4. хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

10.2.5. үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;

10.2.7. хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;

10.2.8. хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;

10.2.9. эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;

10.2.10. энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;

10.2.11. барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;

10.2.12. хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;

10.2.13. хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;

10.2.14. хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;

10.2.15. хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;

10.2.16. аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;

10.2.17. үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;

10.2.18. аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.

10.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно:

10.3.1. хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;

10.3.2. нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;

10.3.3. хог хаягдлыг ил задгай шатаах;

10.3.4. гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;

10.3.5. хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;

10.3.6. аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;

10.3.7. нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН, МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТ

11 дүгээр зүйл. Мэдээллийн нэгдсэн сан

11.3. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу сум дүүрэгт, аюултай хог хаягдлын мэдээг аймаг, нийслэлд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

13 дугаар зүйл. Хог хаягдалтай холбогдох үйл ажиллагаанд тавих хяналт

13.2. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэн тавина.

13.3. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлага

15.1. Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн сав дараахь шаардлагыг хангасан байна:

15.1.1. хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2. галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3. хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

20 дугаар зүйл. Хог хаягдлын төвлөрсөн цэгт хориглох үйл ажиллагаа

20.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгт дараахь хог хаягдал булшлахыг хориглоно:

20.1.1. аюултай хог хаягдал;

20.1.2. халдвартай хог хаягдал;

20.1.3. шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал.

20.2. Хог хаягдал шатаахыг хориглоно.

20.4. Тогтоосон цэгээс бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ САВЛАХ, ТҮР ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ

21.1. Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 8.1.9.а-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.

22 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг савлах

22.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална.

22.2. Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.

23 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах

23.1. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараахь хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно:

23.1.1. сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног;

23.1.2. сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног.

23.2. Тодорхой шалтгааны улмаас энэ хуулийн 23.1-д заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол аймаг, нийслэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр хадгалах зөвшөөрөл авна.

23.3. Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.

23.4. Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэнэ.

23.5. Аюултай хог хаягдлыг хадгалах үед үүссэн шүүрлийг аюултай хог хаягдал гэж үзнэ.

23.6. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг энэ хуулийн 8.1.4-т заасан зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхэд энэ хуулийн 8.1.7.а-д заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлнэ.

23.7. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдал хариуцсан орон тооны болон орон тооны бус ажилтантай байна.

24 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх

24.1. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

24.2. Аюултай хог хаягдал тээвэрлэгч аюултай хог хаягдал үүсгэгчээс тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичигтэй аюултай хог хаягдлыг гэрээний үндсэн дээр хүлээн авч тээвэрлэнэ.

24.7. Аюултай хог хаягдал үүсгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас аюултай хог хаягдлын дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээнд үл

зохицол үүсвэл аюултай хог хаягдал хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно.

24.8.Энэ хуулийн 24.7-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хог хаягдлыг аюултай хог хаягдал үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг тухайн **аюултай хог хаягдал үүсгэгч хариуцна.**

25 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгахад тавигдах шаардлага

25.1.Аюултай хог хаягдал хадгалах, устгах байгууламжийг дараахь байршилд байгуулахыг хориглоно:

25.1.1.усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд;

25.1.3.хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэр болон гадаргын уснаас хоёр километрээс бага зайд;

25.1.4.үерийн усны урсац дайран өнгөрөх зам, талбайд;

25.1.5.ус, намгархаг газарт;

25.1.6.нефть, нүүрс болон байгалийн хийн нөөц бүхий газарт;

25.1.7.шохойн чулуу болон 50 ба түүнээс дээш хувийн карбонатын эрдэс агуулсан үндсэн чулуулагтай газарт;

25.1.9.төмс, хүнсний ногоо, тариалангийн талбайгаас нэг километрээс бага зайд;

25.1.10.орон сууц, олон нийтийн бүс болон зэргэлдээх барилга, байгууламжаас нэг километрээс бага зайд.

25.2.Аюултай хог хаягдал хадгалах, устгах байгууламжийн гадаад хил буюу гадаад орчноос тусгаарласан хашаанаас энэ хуулийн 25.1-д заасан зайг тооцно.

25.3.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламж **дараахь шаардлагыг хангасан байна.**

25.3.2.нэг хувийн чийгийн хангамшилтай жилийн үерийн урсацын хэмжээнд тооцсон эзлэхүүн бүхий гадаргын ус цуглуулах сантай;

25.3.5.зөвшөөрөлгүй хүн нэвтрэх, мал амьтан орохоос хамгаалсан хашаа, харуул хамгаалалттай, байгууламжийн орох, гарах хаалга болон дотор, гадна талбай, зам, устгалын үйл ажиллагааг тасралтгүй хянах хяналтын системтэй;

25.3.6.гадна болон дотор талбайд аюул, ослын үед ажиллах машин, техник, тоног төхөөрөмж ажиллах нөхцөлийг хангасан орц, гарц, замтай;

25.3.7.аюулгүй ажиллагааны болон аюул, ослын үед ажиллах дохиоллын систем, хариу арга хэмжээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис, материалаар тоноглогдсон.

26 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх

26.1.Энэ хуулийн 37.1-д заасан зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхэлж, дараахь шаардлагын дагуу ажиллана.

26.1.1.**аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанаас үүсэж болох аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байна.**

26.1.2.орон нутгийн цагдаа, онцгой байдлын газар, эрүүл мэндийн байгууллагатай аюул, ослын үед хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана.

26.1.3.ажилчдыг тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн сургалтад хамруулна.

26.1.4.энэ хуулийн 26.1.3-т заасан сургалтад хамрагдаагүй ажилтныг бие даалган ажлын байранд ажиллуулахыг хориглоно.

26.1.5.**аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна.**

26.1.6.аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууламж нь онцгой байдлын зохицуулагчтай байна.

26.3.Онцгой байдлын зохицуулагч аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрхтэй.

29 дүгээр зүйл. Тайлагнах

29.1.Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг энэ хуулийн 8.1.7-г-д заасан маягтаар гаргаж, энэ хуулийн 8.1.3-т заасан журмын дагуу хүргүүлнэ.

30 дугаар зүйл. Хяналт-шинжилгээ хийх

30.1.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорхи ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байна.

30.5.Энэ хуулийн 30.1-д заасан хөтөлбөрийн дагуу хяналт-шинжилгээг хийнэ.

33 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалахад тавигдах нэмэлт шаардлага

33.1.Аюултай хог хаягдлыг, хадгалж байгаа аюултай хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийсэн, эсхүл доторлосон бат бөх зориулалтын саванд хадгална.

33.2.Аюултай шингэн хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь асгарсан, алдагдсан хаягдал, хуримтлагдсан хур тунадасыг тогтоон барих хязгаарлалтын системтэй байна.

33.3.Аюултай шингэн хаягдлыг газар доор суурилуулсан саванд хадгалахыг хориглоно.

33.4.Аюултай хуурай хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь хуримтлагдсан хур тунадасыг зайлуулах, шавхах боломжтой, сав нь хуримтлагдсан шингэнтэй хүрэлцэхгүй байхаар өргөгдсөн, эсвэл хамгаалагдсан байна.

33.5.Аюултай хог хаягдал хадгалах талбай нь хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан дээвэртэй байна.

33.6.Нийцгүй хог хаягдлыг нэг саванд хадгалахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ХОГ ХАЯГДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

40 дүгээр зүйл. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах

40.1.Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэнэ.

40.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүн худалдан авах замаар ногоон худалдан авалтыг дэмжинэ.

40.4.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно.

41 дүгээр зүйл. Хог хаягдлын үйлчилгээний хураамж, төлбөр, үйл ажиллагааны санхүүжилт

41.2.Аюултай хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэсэн хог хаягдлаа тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгахтай холбогдон гарах зардалд шаардагдах аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс төлнө.

41.13.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож сум, дүүргийн Засаг дарга мөнгөн урамшуулал олгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААРХИ БОЛОВСРОЛ

42 дугаар зүйл. Хог хаягдлын талаархи боловсрол олгох

42.1.Хог хаягдлын талаархи боловсрол нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад байгальд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаархи мэдлэг олгоход чиглэнэ.

42.5.Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллага нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулах, сургалтын байр болон сургалтад шаардагдах бусад дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

43 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

43.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:

43.1.1.энэ хуулийн 7.1.2-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.2.энэ хуулийн 8.2.1, 8.3.2, 8.5.1, 8.6.2, 9.1.3-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.3.энэ хуулийн 10.2.1, 10.2.4, 10.2.5, 10.2.7, 10.2.9, 10.2.10, 10.2.11-д заасныг зөрчсөн бол хүнийг гучин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.4.энэ хуулийн 10.3.1, 10.3.2-т заасныг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.5.энэ хуулийн 10.3.3, 10.3.4-т заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.6.энэ хуулийн 10.3.5-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.7.энэ хуулийн 10.3.6-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.8.энэ хуулийн 10.3.7-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.9.энэ хуулийн 14.4, 14.5, 14.6, 14.8-д заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.10.энэ хуулийн 14.3-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.11.энэ хуулийн 16.8-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.12.энэ хуулийн 18.1-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.13.энэ хуулийн 20.1, 20.2-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;

43.1.14.энэ хуулийн 20.4-т заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.15.энэ хуулийн 24.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгох;

43.1.16.энэ хуулийн 25.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.17.энэ хуулийн 26.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.18.энэ хуулийн 28.1-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

43.1.19.нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсэд хог хаягдал хаясан иргэн, аж ахуйн нэгжийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг хурааж, зөрчил гаргасан хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр торгох;

43.1.21.энэ хуулийн 40.6-д заасныг зөрчсөн хүнийг нэг зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

М.ЭНХБОЛД

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

2003 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн захиргааны хяналт шалгалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

3¹ дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3¹.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3¹.1.1. "хяналт шалгалт" гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг;

3¹.1.2. "хяналт шалгалтын арга, хэлбэр" гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож байгаа шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг;

5 дугаар зүйл. Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам

5.1. Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид "хяналт шалгалтын байгууллага" гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилна.

5.3. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ хуулийн 5.2-т заасан удирдамжгүйгээр хийж болно.

5⁴ дүгээр зүйл. Хяналт шалгалтын объектын эрсдэлийн ангилал

5⁴.1. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна.

13 дугаар зүйл. Хяналт шалгалтын талаархи байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг

13.1. Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт шалгалтын журам тогтоож ажиллана.

13.2. Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар тавьсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Хяналт шалгалтын шийдвэрийн талаар гомдол гаргах эрх

14.1. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана.

14.2. Гомдлыг хүлээж авсан хяналт шалгалтын байгууллагын эрх баригч түүнийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна. Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж

ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

16 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА**

С.ТӨМӨР-ОЧИР

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ

2008 оны 05 сарын 22 өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг;

3.1.2. “хөдөлмөрийн аюулгүй байдал” гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг;

3.1.3. “хөдөлмөрийн эрүүл ахуй” гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг;

3.1.4. “хөдөлмөрийн нөхцөл” гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг;

3.1.5. “үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл” гэж хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг;

3.1.6. “үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл” гэж ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйлийг;

3.1.7. “ажлын байран дахь эрсдэл” гэж иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлийг;

3.1.8. “эрсдэлийн үнэлгээ” гэж ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явцыг;

3.1.9. “ажлын байр” гэж иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байрыг;

3.1.10. “хурц хордлого” гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;

3.1.11. “тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг;

3.1.12.“нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;

3.1.14.“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх харилцан холбоо бүхий удирдлагын үйл ажиллагааны цогцыг;

3.1.15.“ахуйн байр” гэж иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын өрөө тасалгааг;

3.1.16.“үйлдвэрлэлийн ажлын байрыг хөдөлмөрийн нөхцөлөөр аттестатчилах” гэж гүйцэтгэж буй ажлын аюултай, хортой, хүнд, ачаалалтай байдал нь хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн хэм хэмжээнд нийцэж байгаад үнэлгээ өгөхийг;

3.1.17.“хөдөлмөрийн аюулгүй нөхцөл” гэж ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байхыг;

3.1.18.“үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал” гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг;

3.1.19.“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт” гэж хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг.

3.1.20.“үйлдвэрлэлийн осол” гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг;

3.1.21.“үйлдвэрлэлийн орчин” гэж аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны талбай, гадна орчныг;

3.1.22.“эрсдэлийн түвшин их ажлын байр” гэж хөдөлмөрлөх явцад ажилтанд учирч болзошгүй аюултай хүчин зүйлийн магадлал нь зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байхыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт

9 дүгээр зүйл. Машин механизм, тоног төхөөрөмжид тавих шаардлага

9.1.Үйлдвэрлэлийн зориулалттай, хүний эрүүл мэндэд аюул учруулж болох машин механизм, тоног төхөөрөмжийн талаар ажил олгогч нь дараахь шаардлагыг хангасан байна:

9.1.1. машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг (ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл) нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх;

9.1.2. машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, техникийн паспорттай байх;

9.1.3 машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх;

9.1.4 машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж байх.

9.3.Цахилгааны тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байна.

9.4.Цахилгааны тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, газардуулга, газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна.

9.5.Энэ хуулийн 9.1-9.4-т заасан шаардлагыг хангаагүй машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.

10 дугаар зүйл. Өргөх, зөөх, тээвэрлэх механизмд тавих шаардлага

10.1.Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.

10.2.Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд мэргэжлийн байгууллагаар техникийн магадлагаа хийлгэж, зохих зөвшөөрлийг авсан байна.

10.3.Өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд засвар үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага тодорхой хугацаанд хийж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.

10.4.Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3-т заасан шаардлага хангагдсан байх нөхцөлийг ажил олгогч хангасан байна.

12 дугаар зүйл. Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих шаардлага

12.1.Ажил олгогч нь химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис, түүний нөлөөллөөс ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

12.3.Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцан ажиллагч нь тухайн бодисын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг, дадлагатай байна.

12.5.Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын хэрэглээтэй холбоотой осол, хурц хордлого гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн ослын нэгэн адил судлан бүртгэнэ.

13 дугаар зүйл. Галын аюулгүй байдалд тавих шаардлага

13.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

13.2.Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрт байрлуулна.

тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна.

14 дүгээр зүйл. Эрүүл мэндийн үзлэг

14.1.Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.

15 дугаар зүйл. Ажилтныг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах

15.1.Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй.

15.2.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.

15.3. Ажил олгогч нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг баталж мөрдүүлнэ.

15.4. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар ажил олгогч дүгнэлт гаргуулсан байна. Олон улсын стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд энэ заалт хамаарахгүй.

16 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага

16.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон байна.

16.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь түүнийг орж, гарахад нь саад болохооргүй байдлаар тоноглогдсон байна.

17 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт

17.1.Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтан болон ажил олгогч нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт

27 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зохион байгуулалт

27.1.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна.

27.2.Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.

27.3.Энэ хуулийн 27.2-т заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.3.1.аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөөг боловсруулж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх;

27.3.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих;

27.3.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд үзлэг, шалгалт хийлгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

27.3.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;

27.3.5.ажлын нөхцөл, мэргэжлийн онцлогт тохирсон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтанд олгох, норм, чанар, зохистой хэрэглээнд хяналт тавих;

27.3.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, дүрэм, журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх саналаа ажил олгогчид гаргах;

27.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна.

27.7.Энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.6-д заасан этгээд, аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан ажиллуулах орон тоонд хүрээгүй тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

28 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ажил олгогчийн эрх, үүрэг

28.1.Ажил олгогч нь дараахь үүрэгтэй байна:

28.1.1.үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

28.1.2.үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;

28.1.3.хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх;

28.1.4.ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;

28.1.5.ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх;

28.1.6.ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх;

28.1.7.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар шаардлагатай мэдлэгийг эзэмшсэн байх;

28.1.8.аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;

28.1.9.хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн, хоолоор үнэгүй хангах;

28.1.10.хэт халуун буюу хүйтэн, салхитай, хур тунадастай зэрэг задгай газар, халаалтгүй байранд ажиллаж байгаа ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын дагуу түр завсарлагын үед амрах, дулаацах, хоргодох зориулалтаар тоноглож тохижуулсан ахуйн байраар хангах;

28.1.11.үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоон мэдээллийн талаар тэмдэглэл хөтөлж, холбогдох байгууллагад мэдээлж байх;

28.1.12.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийг ажлын байранд саадгүй нэвтрүүлэх;

28.1.13.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг зөрчсөн талаар илэрсэн зөрчил, дутагдал, эрх бүхий этгээдийн гаргасан шаардлага, дүгнэлтийн дагуу тодорхой арга хэмжээ авч, эргэж мэдэгдэх;

28.1.14.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зориулалтаар нь зарцуулах;

28.1.15.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтанд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр олгох;

28.1.16. Энэ хуулийн 4.1.2, 4.1.3, 4.1.6-д заасан этгээд нь өөрийн ажиллагсадын аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, тэдгээрийг судалж бүртгэх

29 дүгээр зүйл. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед авах арга хэмжээ

29.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авна.

29.2.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрд Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.

29.3.Энэ хуулийн 29.2-т заасны дагуу гаргасан үйлдвэрлэлийн ослын актыг хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хурц хордлогын дүгнэлтийг хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тус тус хянана.

29.5.Ажил олгогч энэ зүйлийн 29.1, 29.2-т заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл үйлдвэрлэлийн осол гарсан, хурц хордлогод өртсөн дүгнэлтийг иргэн, ажилтан зөвшөөрөхгүй бол гомдлоо хөдөлмөрийн мэргэжлийн хяналтын байгууллага болон шүүхэд гаргаж холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

29.6.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэх зардлыг осол гарсан аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

29.7.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын тухай мэдээг тогтоосон журмын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн статистикийн байгууллагад мэдээлнэ.

29.8.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт

35 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт

35.1.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн цех, тасаг, хэсэг, ажлын байр бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина.

35.2.Ажил олгогч дотоодын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах үүрэгтэй.

35.3.Ажилтны төлөөлөгч болон ажилтан нь аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналт тавих үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

36 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

36.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

/шинэчилсэн найруулга/

2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг,

хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.3.“татварын цахим баримт бичиг” гэж татварын хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, эсхүл хүлээн авсан тоон гарын үсгээр баталгаажсан баримт бичгийн иж бүрдлийг;

4.1.4.“тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.5.“татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” гэж нэгдсэн ангилал, код, стандарт, арга зүй, ижилтгэсэн баримтын шаардлагын дагуу үүсгэсэн, цуглуулсан, хүлээн авсан, боловсруулсан, хадгалсан өгөгдөл, мэдээлэл, программ хангамжийн иж бүрдлийг;

4.1.6.“татвар суутгагч” гэж татвар төлөгчийн олсон орлогод татварын хуулиар татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээдийг;

4.1.7.“татварын тайлан” гэж бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хуулийн этгээдийн татварын тайлан, хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн хуудсыг;

7 дугаар зүйл. Татварын төрөл, ангилал

7.1.Татварыг татварын төрөлд ангилах ба тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.

7.3.Улсын Их Хурал, Засгийн газраас хувь хэмжээг нь тогтоосон бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх дараахь татвар улсын татварт хамаарна:

7.3.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

7.3.2.гаалийн албан татвар;

7.3.3.нэмэгдсэн өртгийн албан татвар;

7.3.4.онцгой албан татвар;

7.3.5.авто бензин, дизелийн түлшний албан татвар;

7.3.6.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

7.3.8.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.

7.3.13.агаарын бохирдлын төлбөр.

7.3.14.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж.

7.3.15.ус бохирдуулсны төлбөр.

7.3.16.газрын тосны нөөц ашигласны төлбөр;

7.3.17.газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.

7.4. Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх дараахь татвар орон нутгийн татварт хамаарна:

7.4.1.хувь хүний орлогын албан татвар;

7.4.2.орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар;

7.4.3.үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;

7.4.4. энэ хуулийн 7.3.14-т зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж;

7.4.6.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

7.4.7.ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;

7.4.9.түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;

7.4.11.газрын төлбөр;

7.4.13. галт зэвсгийн албан татвар;

7.4.14.нийслэл хотын албан татвар;

7.4.15.нохойны албан татвар;

7.4.16.өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;

7.4.17.хог хаягдлын үйлчилгээний хураамж;

7.4.18.байгалийн нөөц ашигласны төлбөр.

11 дүгээр зүйл. Татварын хөөн хэлэлцэх хугацаа

11.1.Татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байх бөгөөд Монгол Улсын Иргэний

хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй.

11.2.Татвар, алданги, торгуулийн өрийг төлөхөд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

11.3.Энэ хуулийн 11.1-д заасан хөөн хэлэлцэх хугацааг дараахь байдлаар тоолж эхэлнэ:

11.3.1.тайланг жилийн эцэст нэг удаа гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд уг тайланг гаргаж татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

11.3.2.тайланг сар, улирал бүр гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн татварын тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

11.3.3.борлуулалт хийгдсэнээс хойш тодорхой хугацааны дотор татвар төлөхөөр хуульд заасан татварын төрөл болон суутгаж төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын тайлан гаргах өдрийн дараагийн ажлын өдрөөс;

11.3.4.тайлан гаргахгүй төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын хуульд заасан татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс.

11.4.Татварын албанаас энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан мэдэгдэх хуудас гардуулсан өдрөөр хөөн хэлэлцэх хугацаа таслагдаж, цааш шинээр тоологдоно.

11.5.Татвар төлөгч үйл ажиллагаагаа зогсоосон, татан буугдсан тохиолдолд уг үйл ажиллагаа зогссон өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тооцно.

11.6.Татварын хяналт шалгалтын явцад нөхөн төлүүлэхээр тогтоосон татвар болон алданги, торгуулийн хөөн хэлэлцэх хугацааг татварын улсын байцаагчийн тогтоосон акт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Татвар төлөгч, түүний эрх, үүрэг

12 дугаар зүйл. Татвар төлөгч

12.1.Татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, тодорхой эрх бүхий, эсхүл ажил үйлчилгээ эрхэлж, түүнчлэн газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласан, агаар, ус, хөрс бохирдуулснаас татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна.

15 дугаар зүйл. Татвар төлөгчид үйлчлэх

15.1.Татварын алба, татварын улсын байцаагч хууль тогтоомжоор тодорхойлсон татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь татвар төлөгчид тусалж дараахь үйлчилгээг үзүүлнэ:

15.1.1.татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулах;

15.1.2.татварын хууль тогтоомжийг нэг мөр дагаж мөрдөх, татварын үүргээ тодорхойлох, тайлан, мэдээ гаргахтай холбогдсон заавар, аргачлал, гарын авлага, маягтаар хангах;

15.1.3.татварын хууль тогтоомж, заавар, аргачлалын талаар сургалт зохион байгуулах;

15.1.4.татварын үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар татвар төлөгч хэсгээрээ буюу ганцаарчлан зөвлөлгөө авах боломжийг бүрдүүлэх, тийм зөвлөлгөө өгөх;

15.1.5.олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, татварын албаны цахим хуудсаар дамжуулан нийтийг хамарсан сурталчилгаа, сургалт, мэдээллийн нэвтрүүлэг зохион байгуулах, нийтлэл гаргах.

17 дугаар зүйл. Татвар төлөгчийн эрх

17.1.Татвар төлөгч дараахь эрх эдэлнэ:

17.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдсон мэдээлэл, зөвлөлгөө, татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, аргачлал, маягтыг татварын алба, татварын улсын байцаагчаас авах;

17.1.2.татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;

17.1.3.хууль тогтоомжийн дагуу татвар төлөх хугацааг сунгуулах;

17.1.4.илүү төлсөн татварыг буцаан авах буюу суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах;

17.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах;

17.1.6.татварын албанаас гаргасан акт, дүгнэлт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл танилцсанаас хойш 30 хоногийн дотор гомдлоо захиргааны болон шүүхийн журмаар гаргах;

17.1.7.татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

17.1.8.татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг татварын алба, татварын улсын байцаагчаас шаардах, татварын албаны хууль бус шийдвэр, үйлдлийн улмаас учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

17.1.9.татварын алба, татварын улсын байцаагчийн хууль бус ажиллагаа, шийдвэрийн талаар гомдлоо түүнийг шууд захирдаг болон дээд шатны албан тушаалтанд, түүнчлэн шүүхэд гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь ногдуулсан татвар, торгууль, алдангийг төлөхийг зогсоох үндэслэл болохгүй;

17.1.10.татварын хууль тогтоомжоор ногдсон үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн татварын зөвлөхийн туслалцаа, зөвлөлгөө авах;

17.1.11.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх;

17.1.12.хууль тогтоомжид заасан бусад эрх.

18 дугаар зүйл. Татвар төлөгчийн үүрэг

18.1.Татвар төлөгч дараахь үүрэг хүлээнэ:

18.1.1.татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;

18.1.2. татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ, тайланг гаргаж тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх;

18.1.3. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам болон нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах;

18.1.4. татварын хууль тогтоомж зөрчсөн бол уг зөрчлийг арилгах талаар татварын албанаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

18.1.5. татварын албаны шалгалтын акт, дүгнэлтийг зөвшөөрч байгаа бол гарын үсэг зурах, зөвшөөрөхгүй бол тайлбараа хяналт шалгалт хийсэн татварын албанд ажлын 10 өдөрт багтаан бичгээр гаргаж өгөх;

18.1.6. бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх;

18.1.7. хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагаас авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанд мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх;

18.1.8. Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх;

18.1.9. татвар ногдох эд хөрөнгө, эрхээ бусдын өмчлөлд шилжүүлсэн тухай баримтыг татварын албанд гаргаж өгөх;

18.1.10. нэр, хаяг, тамга, тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, харилцах болон хувийн данс, гарын үсгийг бусдад ашиглуулан татвараас зайлсхийх боломж олгохгүй байх;

18.1.11. эрх бүхий байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээсэлсэн, худалдсан тухайгаа харьяалагдах татварын албанд тухай бүр мэдэгдэх;

18.1.12. банкинд данс нээсэн болон хаасан тухай татварын албанд тухай бүр мэдэгдэх;

18.1.13. татварын алба, татварын улсын байцаагчийн шаардсаны дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдсэн санхүүгийн болон бусад баримт бичгийг гарган өгч татварын хяналт шалгалтад хамрагдах;

18.1.14. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

45 дугаар зүйл. Татварын тайлан үйлдэх, тушаах

45.1. Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу үйлдэж, харьяалах татварын албанд тушаана.

45.2. Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч нь татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг тайлан нь түүнийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.

45.3. Татварын тайланд хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон татвар төлөгч хувь хүн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна.

45.4. Татварын тайланг гаргасан буюу ийнхүү гаргахад оролцсон этгээд уг тайланд гарын үсэг зурах бөгөөд хэд хэдэн этгээд хариуцсан үүргийнхээ дагуу тайлан гаргахад оролцсон бол ерөнхий нягтлан бодогч тайланд гарын үсэг зурна.

45.5. Татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн аливаа этгээд нь энэ тухай баримтыг шилжүүлэн авсан этгээдэд тухай бүр, татварын албанд шаардсан үед гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

47 дугаар зүйл. Татварын хяналт шалгалт

47.1. Татвар төлөгч Монгол Улсын татварын хууль тогтоомжид зааснаар төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэт тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг татварын алба, татварын улсын байцаагч хянан шалгана.

47.3. Татварын алба, татварын улсын байцаагч татвар төлөгч татварын хуулиар тогтоосон эрхээ эдлэх, үүргээ биелүүлэхэд туслах, зөрчил дутагдлыг арилгах зорилгод нийцүүлэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд дараахь хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулна:

47.3.1. татвар төлөгч татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэн татварын ногдлоо өөрөө үнэн зөв тодорхойлон төлөх нөхцөлийг бүрдүүлж, нягтлан бодох бүртгэлийг тогтмол хөтөлж, татварын тайлангаа хугацаанд нь гарган тушааж, татвараа төлж буй эсэхийг тогтоох;

47.3.2. татвар төлөгчийн татварын тайланд тусгаж тайлагнасан татварын ногдол нь бүрэн гүйцэт эсэхийг шалган тогтоох;

47.3.3. нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй, эсхүл татварын тайлангаа тушаагаагүй бол татварын ногдлыг тодорхойлон төлүүлэх.

47.4. Татварын алба, татварын улсын байцаагч нь татварын хяналт шалгалтын ажлыг татвар хураах зардлыг хэмнэн, үр өгөөжтэй байх, татвар төлөгчийн хэвийн үйл ажиллагааг үл алдагдуулах, чирэгдэл бага учруулах шаардлагад нийцүүлэн төлөвлөгөөт болон гэнэтийн, бүрэн буюу хэсэгчилсэн, ганцаарчилсан болон нийтийг хамарсан зэрэг олон улсын жишигт нийцсэн, хуулиар хориглоогүй бүх хэлбэрээр явуулж, аль ч татвар төлөгчийн үүргийн биелэлтийг хэзээ зохистой гэж үзсэн үедээ шалгах эрхтэй.

47.5. татварын хяналт шалгалт хийх талаар татвар төлөгчид ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

58 дугаар зүйл. Татварыг суутган тооцох, буцаан олгох

58.1. Энэ хуулийн 17.1.4-т заасны дагуу татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг дараахь журмаар шийдвэрлэнэ:

58.1.1. тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт суутган тооцох;

58.1.2. татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох;

58.1.3. буцаан олгох.

58.2. Илүү төлсөн татварыг суутган тооцсон бол татварын алба энэ тухай татвар төлөгчид мэдэгдэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Хугацаанд нь төлөөгүй татварын өрийг хураах

61 дүгээр зүйл. Хугацаанд нь төлөөгүй татварын өр

61.1. Энэ хуулийн 54.1.6, 54.2, 57.1-д заасан журмаар тогтоож, сунгасан хугацаанд төлөөгүй татварын өрийг хугацаанд нь төлөөгүй татварын өр гэнэ.

61.2. Хугацаанд нь төлөөгүй татварын өрийг татварын алба хураан барагдуулна.

75 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

75.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

76 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

76.1. Энэ хуулийг 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

1997 оны 12 дугаар сарын 5-ны өдөр

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

4 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим

4.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэд

оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцох, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана.

6 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төрөл

6.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил дор дурдсан төрөлтэй байна:

6.1.1. ерөнхий арга хэмжээ;

6.1.2. тусгай арга хэмжээ;

6.1.3. нэг бүрчилсэн арга хэмжээ.

6.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэнэ.

6.3. Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ гэнэ.

6.4. Тодорхой этгээд гэмт хэрэг үйлдэхээс болон давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ гэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

9 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи аж аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг үүрэг

9.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

9.1.1. байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах;

9.1.2. ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах.

9.1.3. барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

23 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр

2.1 дүгээр зүйл. Зөрчил

1. Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг **зөрчил** гэнэ.

3.4 дүгээр зүйл. Торгох шийтгэл

1. Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.

2. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэг торгуулийн нэгж /цаашид “нэгж” гэх/ нь **нэг мянган төгрөгтэй** тэнцүү байна.

5.9 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих

1.1 Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах.

1.2 ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах хүн-100, хуулийн этгээд-1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.11 дүгээр зүйл. Химийн хорт бодис болон аюултай бодисын тухай хууль зөрчих

1. Химийн хорт, аюултай бодис:

1.6 хадгалах;

1.7 худалдах;

1.8 ашиглах;

1.9 устгах үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Химийн хорт бодис, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаархи стандартыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.12 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

2.1. түүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага:

2.3. аюулгүй байдлын бүсийн дэглэм, журам зөрчсөн бол хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих

1. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлийн талаар олон нийтийг төөрөгдүүлэх мэдээ, мэдээлэл түгээсэн, эсхүл эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалтын дэглэмийг зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Гамшгаас хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор байгуулсан барилга байгууламжийг эвдэж гэмтээсэн, эсхүл зориулалтыг дур мэдэн өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Тусламж үзүүлэгч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.14 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлын тухай хууль зөрчих

1. Иргэн, хуулийн этгээд галын аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүй, эсхүл галын аюулгүй байдлын дүрэм, журам, галын аюулгүй байдлыг хангах талаар тавигдах нийтлэг шаардлагыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүн-100, хуулийн этгээд-1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.3. үйлдвэрийн технологийн горимыг өөрчлөхөд холбогдох хууль, галын аюулгүй байдлын норм, нормативыг зөрчсөн, эсхүл шатах, тослох материалыг зориулалтын бус газар хадгалсан бол хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.2. галын аюултай материал хадгалах, ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахдаа эрх бүхий байгууллагын мэргэжлийн дүгнэлт гаргуулах, эсхүл зөвшөөрөл авах журам зөрчсөн бол хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Шатамхай бодис, эсхүл пиротехникийн эдлэхүүнийг:

6.1. бүртгэх;

6.2. хадгалах;

6.3. тээвэрлэх;

6.4. ашиглах журам зөрчсөн бол хүн-100, хуулийн этгээд-1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.15 дугаар зүйл. Аюулгүй ажиллагааны журам зөрчих

2.Тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг:

- 2.1.бүртгэх;
- 2.2.хадгалах;
- 2.3.ашиглах;
- 2.4.тээвэрлэх;
- 2.5.илгээх;
- 2.6.борлуулах;
- 2.7.олж авах;

2.8.бэлтгэх журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хууль зөрчих

1. Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газарт хаясан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 30, хуулийн этгээд-300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Хог хаягдлыг ил задгай шатаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-50, хуулийн этгээд-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Аюултай хог хаягдлыг:

- 6.1 цуглуулах
- 6.2 савлах
- 6.3 түр байршуулах
- 6.4 тээвэрлэх
- 6.5 устгах
- 6.6 дахин боловсруулах

6.7 хадгалахад эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авахаар заасныг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийгдсэн нь тогтоогдсон бол хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчих

5.3 тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн бол хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.16 дугаар зүйл. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих

1. Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-1000, хуулийн этгээд-10000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-100, хуулийн этгээд-1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.2 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчих

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчиж:

1.1. үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч барааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хэрэглэгчийг хангах;

1.3. бараанд засвар хийх, техникийн үйлчилгээ үзүүлэх, чанарын доголдлыг арилгах үүргээ биелүүлээгүй бол хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүргээ хэрэгжүүлээгүй бол хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Бараа, ажил, үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, эсхүл хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулсан, эсхүл хууль, гэрээнд заасан чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан бараа хэрэглэх, ажил,

үйлчилгээгээр хангуулах эрхийг зөрчсөн бол хүн-2000, хуулийн этгээд-20000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Үйлдвэрлэгч, худалдагч барааны баталгаат хугацааны шаардлагыг хангаагүй бараа борлуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил үйлчилгээ нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд гэм хор учруулсан, эсхүл заавал мөрдөх стандартын шаардлага хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-900, хуулийн этгээд-9000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой худал мэдээлэл өгсний улмаас хэрэглэгчийн эрх ашигт хохирол учирсан бол хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.3 дугаар зүйл. Хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах

1. Хуурамчаар үйлдэхээс хамгаалсан тохирлын тэмдэг заавал байх бараа, бүтээгдэхүүнийг ашиг олох зорилгоор:

1.3 хадгалсан;

1.4 тээвэрлэсэн

1.5 борлуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.4 дүгээр зүйл. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих

1. Зөвшөөрөлтэйгээр эрхлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хүн-50, хуулийн этгээд-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ явуулсан бол хүн-50, хуулийн этгээд-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.15 дугаар зүйл. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчих

1.2 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журам хангаж ажиллаагүй бол хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүн-400, хуулийн этгээд-4000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулаагүй бол хүн-75, хуулийн этгээд-750 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.16 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль зөрчих

3. Ажилтныг хуульд заасан илүү цагаар ажиллуулах хязгаарлалтыг зөрчиж илүү цагаар ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-150, хуулийн этгээд-1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.3. хүнийг ажилд авахдаа түүнтэй хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулахгүйгээр ажил, үүрэг гүйцэтгүүлсэн;

4.5 хөдөлмөрийн хамтын маргаан шийдвэрлэх, хэлэлцээ хийхэд оролцсон ажилтны төлөөлөгчдөд Хөдөлмөрийн тухай хуульд заасныг зөрчиж сахилгын шийтгэл ногдуулсан, эсхүл ажлаас нь өөрчилсөн, эсхүл халсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-150, хуулийн этгээд-1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Хөдөлмөрийн дотоод журам, ажил, албан тушаалын жагсаалт, ажлын байрны тодорхойлолт болон албан тушаалын лавлах, хөдөлмөрийн норм, норматив, үндсэн цалингийн сүлжээ, жишгийг баталж мөрдөөгүй, өөрийн буруугаас нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээгээгүй, зохих бичилтийг хийж баталгаажуулаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд цуцалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж ажил олгогчийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Хөдөлмөрийн гэрээ байгуулсан өдрөөс эхлэн:

8.1. иргэнийг ажилд авсан тушаал гаргаагүй;

8.2. нийгмийн даатгалын дэвтэр нээгээгүй

8.3. эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээгээгүй

8.4. нийгмийн даатгалын, эсхүл эрүүл мэндийн даатгалын дэвтэрт зохих бичилтийг хийж баталгаажуулаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-150, хуулийн этгээд-1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9. Ажил олгогч:

9.1. ажилтныг хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллуулж байгаа тохиолдолд ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага үндсэн цалин, хөлс олгосон

9.2 ажилтны цалин хөлсийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл саатуулсан

9.3 ажилтны буруугүйгээс үүссэн сул зогсолтын олговрыг олгоогүй, эсхүл түүнийг хуулиар тогтоосон хэмжээнээс доогуур тогтоож олгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.17 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих

1. Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцсон шимтгэлийг хугацаандаа төлөөгүй бол шимтгэлийг тооцсон алдангийн хамт нөхөн төлүүлж хүн-200, хуулийн этгээд-2000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлого нуусан, эсхүл худал мэдүүлсэн, эсхүл эрх бүхий байгууллагаас эцэслэн тогтоосон төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэл, алданги, торгуулийг төлөхөөс зайлсхийсэн нь эрүүгийн

хариуцлага хүлээлгэхээргүй бол хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.19 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль зөрчих

1. Даатгуулагчийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд хариуцан төлүүлэх этгээд нь шимтгэлийг төлөх, хуульд заасан этгээдээр төлүүлэх үүргээ биелүүлээгүй бол төлбөл зохих шимтгэлийг нөхөн төлүүлж хүн-200, хуулийн этгээд-2000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.21 дүгээр зүйл. Тайлан, мэдээ, тооллого, судалгаа, бүртгэлийн журам зөрчих

2. Хуулийн дагуу улсад гаргаж өгвөл зохих бүртгэл, тайлан, мэдээг гаргаж өгөөгүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хожимдуулсан, эсхүл санаатайгаар буруу гаргасан бол хүн-50, хуулийн этгээд-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.24 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль зөрчих

2. Савласан бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, холбогдох дүрэм, журам, стандартыг зөрчиж савласан бүтээгдэхүүн худалдсан бол хүн-100, хуулийн этгээд-1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл улсын бүртгэлд бүртгэгдээгүй, баталгаажуулалтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг үйлдвэрлэсэн, худалдсан, эсхүл суурилуулсан, эсхүл завсарласан бол хүн-100, хуулийн этгээд-1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.25 дугаар зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль зөрчих

3. Итгэмжлэгдсэн байгууллага тохирлын үнэлгээг итгэмжлэлээр тогтоосон хүрээнд явуулах эрхээ хэтрүүлж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-200, хуулийн этгээд-2000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Стандарт, тохирлын үнэлгээний төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ, мэдүүлгийг хуурамчаар гаргасан бол

хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-30, хуулийн этгээд-300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах объектод тогтоосон үндэсний стандартыг мөрдөөгүй, эсхүл үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт шаардлагыг хангаагүй байгууллагын стандартыг баримтлан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.2 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих

1. Төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд:

1.1. хяналт шалгалтаас зайлсхийсэн;

1.2. дотоод хяналт шалгалтын журам тогтоож мөрдүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд төрийн хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг:

2.1. гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан;

2.2. засварласан;

2.3. гэмтээсэн;

2.4. зайлсхийсэн;

2.5. устгасан;

2.6. хуурамч баримт бичиг гаргаж өгсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.18 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчих

1.6 аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүргээ биелүүлээгүй;

1.8 харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлж байгаа санхүүгийн тайланг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх

удирдлага, эсхүл ерөнхий нягтлан бодогч цахим гарын үсэг зурж баталгаажуулаагүй;

1.9 харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийх үүргээ биелүүлээгүй;

1.10 хуульд заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлээгүй;

1.11 нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээсэн аж ахуйн нэгж, байгууллага нь жилийн санхүүгийн тайлаг хуульд заасан хугацаанд толгой компанийн харилцагч харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлээгүй;

1.12 нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг Архивын тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгалах үүргээ биелүүлээгүй;

1.16 анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэсэн, санхүүгийн тайланд тусгасан;

1.17 нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргаагүй;

1.18 нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтлөөгүй;

1.20 аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгалах үүргээ биелүүлээгүй;

1.23 удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллаагүй;

1.24 нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байх үүргээ биелүүлээгүй;

11.19 дүгээр зүйл. Татварын ерөнхий хууль зөрчих

6. Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

6.1 хууль тогтоомжид заасан тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд гаргаж өгөөгүй;

6.5 Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол хүн-150, хуулийн этгээд-1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.2 татварын албанаас дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;

8.3 шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй алга болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаагаа үл мэдэгдэж татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн бол татварыг нөхөн төлүүлж хүн-400, хуулийн этгээд-4000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.4 татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах талаархи хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хүн-400, хуулийн этгээд-4000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.1 бэлэн мөнгөний бүртгэлийн тасалбар олгоогүй бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн хоёр хувь;

12.2 бэлэн мөнгөний тасалбарыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, хүнийг нөхөн төлүүлэх татварын 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.4 дүгээр зүйл. Авто замын тухай хууль зөрчих

2.3 авто замын зурвас газарт худалдаа хийсэн, эсхүл авто замын ашиглалттай холбоогүй бусад үйл ажиллагаа явуулсан хүн-150, хуулийн этгээд-1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.5 дугаар зүйл. Авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэгээг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах

12. Зам, эсхүл замын байгууламж дээр:

12.1 автомашин угаах;

12.2 худалдаа наймаа хийх зэргээр замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-50, хуулийн этгээд-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.2 түргэн, үйлчилгээний цэг, чингэлэг байрлуулах;

13.3 үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах;

13.4 үзвэр, үзэсгэлэнгийн зүйл байрлуулах зэргээр замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-500, хуулийн этгээд-5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15. Шатах тослох материалыг төвлөрсөн хот, суурин газрын замаар өдрийн цагаар тээвэрлэсэн бол хүн-300, хуулийн этгээд-3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.6 дугаар зүйл. Автотээврийн тухай хууль зөрчих

9. Хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх **дүрэм, журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүн-25, хуулийн этгээд-250 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**

13. Авто үйлчилгээний байгууллага нь хуульд **заасан шаардлагыг хангаагүй бол хүн-50, хуулийн этгээд-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.**

15.2 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах

1.Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор:

1.1.тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг бусдад уриалсан;

1.2.хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн;

1.3.хийсэн үйл ажиллагаанд нь саад учруулсан, эсхүл хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.2 дугаар зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль зөрчих

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын:

1.1.бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн;

1.2.нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн;

1.3.нутаг дэвсгэрт паспорт, паспортыг орлох баримт бичиг, эсхүл оршин суух үнэмлэхээ биедээ авч явах журам зөрчсөн;

1.4.нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн;

1.5.хөрш орнуудтай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан хил орчмын нутаг дэвсгэрт зорчих бичиг баримтаар зөвшөөрснөөс бусад нутаг дэвсгэрт зорчсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Гадаадын иргэнийг хууль тогтоомжид заасан хугацаанд зохих байгууллагад бүртгүүлээгүй бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад:

3.1.хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй;

3.2.оршин суух хугацааг хэтрүүлсэн;

3.3.визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэлийн дээд хэмжээ нь хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс хэтрэхгүй байна.

4.Уригч нь гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад:

4.1.хуульд заасан хугацаанд оршин суух зөвшөөрөл аваагүй;

4.2.оршин суух зөвшөөрлийн хугацааг хэтрүүлсэн;

4.3.визийн байх хугацааг хэтрүүлсэн бол гадаадын иргэн тус бүрээр зөрчилд тооцон хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

17.1 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА

Ц.НЯМДОРЖ

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

17.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх

1.Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Нийтийн эзэмшлийн зам харилцаа, цахилгаан, дулаан, холбоо, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.2.бусдад их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

17.9 дүгээр зүйл.Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах

1.Бусдын эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

17.11 дүгээр зүйл.Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх

1.Нийтийн эзэмшлийн зам харилцаа, цахилгаан, дулаан, холбоо, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг болгоомжгүйгээр устгасан, гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Бусдын эд хөрөнгөд болгоомжгүйгээр ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

18.3 дугаар зүйл.Татвар төлөхөөс зайлсхийх

1.Татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний

татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

18.14 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх

1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл ногдох их хэмжээний орлогыг нуусан, худал мэдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

18.16 дугаар зүйл.Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих

1.Бусдын барааны тэмдэг, эсхүл газар зүйн заалтыг ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулан хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хадгалсан, тээвэрлэсэн, худалдсан, улсын хилээр нэвтрүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.байнга тогтвортой үйлдсэн;

2.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас

гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

20.11 дүгээр зүйл. Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях

1. Хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлөх аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг зориулалтын бус газар хаясан; хог хаягдлын зэрэглэлийг санаатайгаар буруу тогтоож зориулалтын бус газар хаясан, устгасан, улсын хилээр нэвтрүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас:

2.1. хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон;

2.2. их хэмжээний хохирол учирсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

21.1 дүгээр зүйл. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах

1. Хэрэг шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг зориуд устгасан, нуусан, засварласан, өөрчилсөн, хуурамчаар

үйлдсэн, эсхүл нотлох баримтыг хуурамч болохыг мэдсээр байж хууль сахиулагчид, прокурорт, шүүхэд гаргаж өгсөн бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хууль сахиулагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч, нотлох баримтыг хадгалах, хамгаалах үүрэг бүхий алба хаагч, ажилтан үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

21.2 дугаар зүйл. Худал мэдүүлэх

1. Гэрч, хохирогч мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд үнэн зөв мэдүүлэг өгөхөө илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал мэдүүлэг өгсөн бол гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Гэрч, хохирогч бусдыг гэмт хэрэг үйлдсэн гэж мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд зориуд худал мэдүүлсэн, гүтгэсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

1. Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн

эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

27.10 дугаар зүйл.Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.Автотээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;

2.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн;

2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж;

2.4.их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

ДАРГА

З.ЭНХБОЛД

АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД АНГИЛАЛ ТОГТООХ ЖУРАМ

Зам, тээврийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагад (цаашид “авто үйлчилгээний байгууллага” гэх) эрх бүхий байгууллагаас үйлчилгээний ангилал тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг өмчийн төрөл харгалзахгүй авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон ангилал тогтоох, хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар ангиллаа тогтоолгоогүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

1.4.Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон байгууллага гүйцэтгэнэ.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1.Энэхүү журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“Техникийн хяналтын шинжээчийн дүгнэлт” гэж авто үйлчилгээний байгууллагын үйлчилгээ, тоног төхөөрөмж, ажлын байрны орчин нөхцөл, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлт нь эрх бүхий байгууллагаас батлан гаргасан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартаар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон баримт (цаашид “шинжээчийн дүгнэлт” гэх).

2.1.2.“Ангилал тогтоох” гэж тохирлын гэрчилгээнд үндэслэн авто үйлчилгээний байгууллагын боловсон хүчин, барилга байгууламж, техник, технологи нь тухайн үйлчилгээний ангилалд тавигдаж буй шаардлагад тохирч буй эсэхийг тодорхойлж баталгаажуулах үйл ажиллагаа.

2.1.3.“Авто үйлчилгээний мэдээллийн сан” гэж “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.-д заасан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн төрөлжсөн дэд сан (цаашид “мэдээллийн сан” гэх).

Гурав. Ангилал тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1.Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ангилал тогтоолгох эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгосны үндсэн дээр тухай ангилалд тохирсон хүрээний үйлчилгээ эрхэлнэ.

3.2.Ангилал тогтоох эрх бүхий байгууллага нь ангилал тогтоолгох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх,хянан үзэж шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, гэрээ байгуулах,ангилал тогтоолгосон гэрчилгээ олгох зэрэг ажлыг зохион байгуулна.

3.3.Үйлчилгээний ангиллыг тогтоохдоо тохирлын баталгаа, шинжээчийн дүгнэлтэд үндэслэн тогтооно.

3.5.Ангилал тогтоох үйл ажиллагаа нь цахим хэлбэрээр явагдах бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээр нь үзэх, тодруулаг хийж болно.

3.6.Авто үйлчилгээний байгууллага нь ангилал тогтоолгох хүсэлтээ мэдээллийн сан дах маягтын дагуу ангилал тогтоох эрх бүхий байгууллагад гаргана.

3.7.Ангилал тогтоолгох хүсэлтэд дараах материалыг хавсаргана.

Үүнд:

3.7.1.Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар(иргэний нэр дээр үйл ажиллагаа явуулах бол иргэний үнэмлэхний хуулбар);

3.7.2.Үйлчилгээний хүчин чадал, тоног төхөөрөмжийн тухай товч танилцуулга;

3.7.3.Тохирлын гэрчилгээний хуулбар;

3.7.4.Шинжээчийн дүгнэлт;

3.7.5.Үйлчилгээний нэр төрөл, тэдгээрийг гүйцэтгэх технологийн карт;

3.7.6.Үйлчилгээний үнэ тариф, ажиллах цагийн хуваарь.

3.8.Ангилал тогтоох эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаар хянан үзэж ажлын 5 хоногийн дотор “Авто үйлчилгээ-Ангилал, ерөнхий шаардлага” MNS 5025:2010 стандартад заасан хүрээний үйлчилгээ эрхлэх ангиллын гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

3.9.Ангилал тогтоох эрх бүхий байгууллагын эрх, үүрэг

3.9.1.ангилал тогтоолгох хүсэлтийг хүлээн авч хянан үзэж шаардлага хангаж буй тохиолдолд зохих ангиллын гэрчилгээг тогтоосон хугацаанд олгох;

3.9.2.тухайн ангиллын үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага хангаагүй тохиолдолд ангилал тогтоож, гэрчилгээ олгохоос татгалзах;

3.9.3.ангилал тогтоолгосон байгууллагын дэлгэрэнгүй мэдээллийг мэдээллийн санд бүртгэх;

3.9.4.ангилал тогтоолгосон байгууллагад мэдээллийн санд техникийн үйлчилгээ, засварын тухай мэдээлэл оруулах эрх олгох, эрхийг цуцлах;

3.9.5.ангилал тогтоолгосон байгууллагатай гэрээ байгуулах, гэрээг тогтоосон хугацаанд дүгнэх, ангиллын гэрчилгээг сунгах, хүчингүй болгох;

3.9.6.ангилал тогтоолгосон байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах;

3.9.7.гэрээний нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

3.9.8.авто үйлчилгээний мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагаа, шинэчлэлийг хариуцна;

3.9.9.авто үйлчилгээний талаарх статистик мэдээтайланг жилийн эхний хагас болон жилийн эцэс, мөн шаардлагатай тохиолдолд тухай бүр нь гарган автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.10.Ангилал тогтоох эрх бүхий байгууллага нь ангилал тогтоолгосон байгууллагатай тухайн ажил үйлчилгээг өөрийн ангиллын хүрээ, хүчин чадал, технологийн карт, цагийн хуваарийн дагуу үзүүлэх талаар болон тухайн хоёр байгууллагын эрх, үүрэг, хариуцлагын тухай тохиролцож гэрээ байгуулна.

3.11.Ангилал тогтоолгосон хугацаа, түүнийг сунгах

3.11.1.ангилал тогтоосон гэрчилгээг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

3.11.2.гэрчилгээний хугацааг сунгахдаа шинжээчийн дүгнэлтийг үндэслэн анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгаж болно.

3.11.3.тухайн үйлчилгээний байгууллагад тавигдах нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд гэрчилгээний хугацааг сунгахгүй.

3.12.Ангилал тогтоолгосон гэрчилгээг түдгэлзүүлэх.

3.12.1.үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллага, автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн ангилал тогтоосон эрх бүхий байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

3.12.2.үйл ажиллагааг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тухай мэргэжлийн хяналтын байгууллага, автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн ангилал тогтоосон эрх бүхий байгууллага ангилал тогтоосон гэрчилгээг сэргээнэ. Ингэхдээ тухайн гэрчилгээг анх олгосон хугацаанаас нь үргэлжлүүлнэ;

3.13.Ангилал тогтоосон эрх бүхий байгууллага нь дараах тохиолдолд ангилал тогтоолгосныг хүчингүйд тооцно. Үүнд:

3.13.1.эзэмшигч хүсэлт гаргасан;

3.13.2.хуулийн этгээд татан буугдсан;

3.13.3.гэрчилгээнд заасанангилалын үйлчилгээг шалтгаангүйгээр гурван сараас дээш хугацаагаар эрхлээгүй буюу ангилалд тавигдах шаардлагыг хангахгүй болсон;

3.13.4.үйлчлүүлэгчдээс удаа дараа (2 ба түүнээс дээш) гомдол гарч тэр нь мэргэжлийн байгууллагаас үндэслэлтэй гэж тогтоосон;

3.13.5.ангиллын гэрчилгээг бусдад шилжүүлсэн, худалдсан, барьцаалсан;

3.13.6.гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн.

3.14.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон тохиолдолд ангилал тогтоосон эрх бүхий байгууллага энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

3.15.Авто үйлчилгээний байгууллага нь тогтоолгосон ангиллаа өөрчлөх, нэмэгдүүлэх тохиолдолд зөвхөн тухай ангилалд хамаарах хүрээнд шинжээчийн дүгнэлт гаргуулна.

3.16.Шинжээчийн дүгнэлтэд үндэслэн үйлчилгээний ангиллыг дахин тогтоон гэрчилгээ олгоно.

3.17.Үйлчилгээ эрхлэх байгууллага нь олон байршилд үйл ажиллагаа эрхлэх бол салбар тус бүрт тохирлын гэрчилгээ авсан байна.

3.18.Үйлчлүүлэгч нь үйлчилгээтэй холбоотой гомдлоо тухайн байгууллагын удирдлагад гаргаж шийдвэрлүүлнэ. Хэрэв тухайн үйлчилгээний байгууллага шийдвэрлээгүй, эсвэл гаргасан шийдвэр үйлчлүүлэгчийн сэтгэлд нийцэхгүй бол ангилал тогтоох эрх бүхий байгууллага болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ. Үйлчилгээтэй холбоотой гомдлыг холбогдох байгууллага 14 хоногийн дотор шалгаж хариу өгнө.

---o0o---

Хавсралт А /Гэрчилгээний арын нүүр/

Ангилал тогтоох эрх бүхий
байгууллагын таних тэмдэг

1.Байгууллагын хаяг: (ангилал тогтоолгосон байгууллага)

..... аймаг (нийслэл)-ийн сум
(дүүрэг)-ын хорооны нутаг дэвсгэрт байрлах

Регистрийн дугаар

2.Авто үйлчилгээний ангилал:

**АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АНГИЛАЛЫН ГЭРЧИЛГЭЭ**

“.....” ХХК-д

..... ын захирал (дарга)-ын 20 ... оны
дугаар сарын (ангилал тогтоосон байгууллагын нэр)

өдрийн ... тоот тушаалыг үндэслэн авто үйлчилгээний ...
. ангиллын гэрчилгээ олгов.

ГАРЫН ҮСЭГ

Гэрчилгээ олгосон огноо.....

Хүчинтэй хугацаа

д/д	Ангилал	Хүчинтэй хугацаа
1		
2		
3		
4		
5		

3.Нэмэлт өөрчлөлт:

д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэглэл

Энэхүү гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй.

Энэхүү гэрчилгээ нь засвартай бол хүчингүй.

АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛ ТОГТООЛГОХ
БАЙГУУЛЛАГААС АВАХ ЦАХИМ ХҮСЭЛТИЙН ЗАГВАР

Нэг. Аж ахуйн нэгжийн мэдээлэл

№	Байгууллагын мэдээлэл	Танилцуулга
1	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	
2	Байгууллагын хаяг	
3	Үйл ажиллагааны чиглэл	
4	Улсын бүртгэлийн гэрчилгээний №	
5	Байгууллагын регистр	
6	Өмчийн хэлбэр	
7	Удирдлагын нэр холбогдох утас, майл хаяг	

Хоёр. Ангилал тогтоолгох хүсэлт

№	Ажил үйлчилгээний төрөл	Ангилал	Хүсэлт
“А” хүрээний ажил үйлчилгээ: Авто машины хөдөлгөөний аюулгүй байдлыг шууд хангахтай холбоотой агрегат, зангилаа, механизм /явах анги, тоормос, гэрэлтүүлэг, дохиоллын систем гэх мэт/-ын иж бүрэн засвар, үйлчилгээ, оношлогоо хийх			
1	Хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бүх агрегат, механизм, зангилааны засвар, үйлчилгээг иж бүрнээр хийх	A1	
2	Хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой үндсэн агрегат, механизм, зангилааны засвар үйлчилгээг төрөлжсөн хэлбэрээр хийх	A2	

3	Хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой зарим агрегат, механизм, зангилааны засвар үйлчилгээг хэсэгчилсэн хэлбэрээр хийх	A3	
“B” хүрээний ажил үйлчилгээ: Хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхтэй холбоотой агрегат, зангилаа /хөдөлгүүр, хүч дамжуулах анги, кузов засвар, авто машин угаалга, явуулын болон дуудлагын үйлчилгээ, оёдол, доторлогоо, засвар үйлчилгээ, оношлогоо гэх мэт/ иж бүрнээр гүйцэтгэх			
4	Авто машины хөдөлгөөний аюулгүй байдалд шууд холбоогүй боловч хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхтэй холбоотой бүх агрегат, зангилаа, механизмын засвар үйлчилгээг иж бүрнээр гүйцэтгэх	B1	
5	Авто машины хөдөлгөөний аюулгүй байдалд шууд холбоогүй боловч хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхтэй холбоотой агрегат, зангилаа, механизмын засвар үйлчилгээг төрөлжсөн хэлбэрээр хийх	B2	
6	Авто машины хөдөлгөөний аюулгүй байдалд холбоогүй зарим агрегат, зангилаа, механизмын засвар үйлчилгээг хэсэгчилсэн хэлбэрээр хийх	B3	
“B” хүрээний ажил үйлчилгээ: Автомашин, сэлбэг худалдах, авто бирж, автотехникийн зах ажиллуулах, сэлбэг хэрэгсэл, тосолгооны болон ашиглалтын бусад материалаар хангах, цэнэглэх, авто зогсоолын үйлчилгээ эрхлэх			
7	Автомашин, сэлбэг хэрэгсэл, тослох материалыг үйлдвэрлэгчээс шууд бөөнөөр нийлүүлдэг дистрибьютерын үйлчилгээ үзүүлэх	C1	
8	Авто бирж, автотехникийн зах, төв ажиллуулах зэргээр авто үйлчилгээ эрхлэгчдэд ажлын байраар хангах болон бусад үйлчилгээ үзүүлэх	C2	
9	Сэлбэг хэрэгсэл, тосолгооны болон ашиглалтын бусад материалын жижиглэн худалдаа, авто зогсоол болон бусад худалдаа үйлчилгээ эрхлэх	C3	

Гурав. Үйлдвэрлэл үйлчилгээний барилга байгууламж

№	Барилга байгууламж	Нэгж	Тайлбар
1	Байршил, Хаяг		
2	Байрны эзэмшил		өөрийн түрээсийн
3	Үйлдвэрлэлийн байрны хэмжээ	м ²	
4	Зогсоолын талбай	м ²	
5	Галын аюулгүй байдлыг хангасан байдал	ОБГ-ын дүгнэлт	
6	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн дүгнэлт	БО-ын дүгнэлт	
7	Ажилчдын хувцас солих өрөө	м ²	
8	Амрах өрөө	м ²	
9	Бие засах газар, гар угаах газар	Тоо	

Дөрөв. Технологийн тоног төхөөрөмж

№	Нэрс	Танилцуулга
1	Технологийн карт	
2	Тоног төхөөрөмжийн товч танилцуулга	
3	Тоног төхөөрөмжийн тоо хэмжээ	
4	Тоног төхөөрөмжийн хүчин чадал	
5	Тоног төхөөрөмжийн баталгаажилт	
6	Тоног төхөөрөмжийн насжилт	
7	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа	

Тав. Хүний нөөц

№	Ажлын байрны нэр	Инженер техникийн ажилтны тоо	Мэргэшсэн байдал

АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БҮРТГЭХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Байгууллагын мэдээлэл

1	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	
2	Байгууллагын хаяг	
3	Үйл ажиллагааны чиглэл	
4	Улсын бүртгэлийн гэрчилгээний №	
5	Байгууллагын регистр	
6	Өмчийн хэлбэр	
7	Удирдлагын нэр холбогдох утас, майл хаяг	
8	Авто үйлчилгээний ангилал, төрөл	
9	Тухайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа	
10	Ангилал тогтоолгосон хугацаа	
11	Дуусах хугацаа	

Хоёр. Хүний нөөцийн мэдээлэл

1	Овог	
2	Нэр	
3	Албан тушаал	
4	Регистерийн дугаар	
5	Хүйс	
6	Иргэншил	
7	Мэргэжил	
8	Мэргэшил	
9	Мэргэжлийн үнэмлэх, дипломын дугаар	

10	Мэргэжлээрээ ажилласан жил	
11	Тухайн байгууллагад ажилласан жил	

Гурав. Барилга байгууламж

1	Байршил, Хаяг		
2	Байрны эзэмшил		
3	Үйлдвэрлэлийн байрны хэмжээ	м ²	
4	Зогсоолын талбай	м ²	
5	Галын аюулгүй байдлыг хангасан байдал	ОБГ-ын дүгнэлт	
6	Ажилчдын хувцас солих өрөө	м ²	
7	Амрах өрөө	м ²	
8	Бусад		

Дөрөв. Тоног төхөөрөмжийн мэдээлэл

Хавсралт В

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Замын цагдаагийн байгууллага

Зам, тээврийн осолд холбогдсон гэмтэл

- Их гэмтэлтэй
- Дунд гэмтэлтэй
- Бага гэмтэлтэй

Хоёр. Онцгой байдлын байгууллага

	Их гэмтэлтэй	Дунд гэмтэлтэй	Бага гэмтэлтэй
Гал түймэрт өртсөн			
Үер, усанд өртсөн			
Бусад			

Гурав. Даатгалын байгууллага

Нөхөн олговор олгосон эсэх

Дөрөв. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын байгууллага

Техникийн хяналтын үзлэгийн дүнгийн мэдээлэл

Тав. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн байгууллага

Марк өөрчилсөн

- Зориулалт өөрчилсөн
- Бүртгэлээс хасагдсан
- Ашиглалтаас хасагдсан

---o0o---

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСВАР ХИЙХ ЖУРАМ

Зам, тээврийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн
90 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь авто тээврийн хэрэгслийн хадгалалт, техникийн үйлчилгээ, засвар болон ашиглалттай холбогдсон материалаар хангах үйлчилгээ (цаашид “авто үйлчилгээ” гэх) эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг өмчийн төрөл харгалзахгүй авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3.Автотээврийн тухай хууль болон холбогдох стандарт, дүрэм, журмаар тогтоосон шаардлагыг бүрэн хангаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага “Авто үйлчилгээ-Ангилал, ерөнхий шаардлага” MNS 5025:2010 стандартад заасан ангиллын хүрээнд үйлчилгээ эрхэлж болно.

1.4.Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхдээ холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт болон оюуны өмчийн харилцааны тухай болон патенттай холбоотой Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрийг мөрдөн ажиллана.

1.5.Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхдээ тохирлын үнэлгээнд хамрагдаж тохирлын баталгаа авсан, эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгосон байна.

1.6.Авто үйлчилгээний байгууллага нь тухайн үйлчилгээнд тавигдах шаардлагыг хангаж буй эсэх талаар жил бүр тохирлын баталгаанд хамрагдсан байна.

1.7.Үйлчилгээндээ Үндэсний тохирлын тэмдэг, Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001, Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001 стандартыг нэвтрүүлсэн авто үйлчилгээний байгууллагыг тохирлын үнэлгээнд хамруулахгүй.

1.8.Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах этгээдэд тавих шаардлагыг үндэсний стандартаар тогтооно.

1.9.Авто үйлчилгээ нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- 1.9.1.техникийн үйлчилгээ, засвар
- 1.9.2.ашиглалтын материалаар хангах
- 1.9.3.тээврийн хэрэгслийн хадгалалт

1.10.Авто үйлчилгээний байгууллагын ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулахгүй байх, үйл ажиллагаандаа заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байна.

1.11.Авто үйлчилгээний байгууллага нь орон нутгийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан тухайн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тавигдаж буй нийтлэг шаардлагыг мөрдөж ажиллана.

1.12.Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл болон бүтээгдэхүүнтэй холбоотой зохиогчийн эрх, патент, лиценз, гэрчилгээ эзэмшигчийн зохих зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэгчийн болон бүтээгдэхүүний нэрийг үйлчилгээндээ ашиглахыг хориглоно.

1.13.Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байр, ажил мэргэжлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Нэр томьёоны тайлбар

2.1.Энэхүү журамд заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“Техникийн хяналт” гэж авто үйлчилгээний байгууллагын үйлчилгээ, ажлын байрны орчин нөхцөл нь холбогдох хууль, стандарт, техникийн зохицуулалт, норм, нормативт заасан үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг мэргэшлийн үүднээс тодорхойлох үйл ажиллагаа;

2.1.2.“Тохирлын үнэлгээний байгууллага” гэж авто үйлчилгээний байгууллагад техникийн хяналт хийх эрх бүхий байгууллагыг;

2.1.3.“Техникийн хяналтын шинжээч” гэж техникийн хяналт хийж дүгнэлт гаргах эрх бүхий этгээд;

2.1.4.“Техникийн хяналтын шинжээчийн дүгнэлт” гэж авто үйлчилгээний байгууллагын үйлчилгээ, тоног төхөөрөмж, ажлын байрны орчин нөхцөл, хэвийн ажиллагаа, аюулгүй байдлын үзүүлэлт нь эрх бүхий байгууллагаас батлан гаргасан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартаар тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон баримт(цаашид “шинжээчийн дүгнэлт” гэх);

2.1.5.“Авто үйлчилгээний мэдээллийн сан” гэж “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.-д заасан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн төрөлжсөн дэд сан (цаашид “мэдээллийн сан” гэх);

2.1.6.“Баталгаат хугацаа” гэж авто үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд гаргаж өгсөн хугацааг.

2.2.Энэхүү журамд ишлэл болгосон эрх зүйн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд албан ёсны хамгийн сүүлийн эх материалыг татаж хэрэглэнэ.

Гурав. Техникийн болон засварын үйлчилгээ

3.1.Техникийн болон засварын үйлчилгээнд тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн байдал, найдварт ажиллагааг хангахад чиглэгдсэн бүх төрлийн техникийн үйлчилгээ, засвар, угаалга зэрэг үйлчилгээ хамаарна.

3.2.Техникийн болон засварын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь автотээврийн салбарын мэргэжлийн байгууллага байх бөгөөд инженер техникийн ажилчид нь тухайн ажил, үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн үнэмлэх, зэрэгтэй байна.

3.3.Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийхдээ үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдлөг болгон ашиглах бөгөөд технологийн карт, аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулж мөрдөн ажиллана.

3.4.Техникийн болон засварын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь авто угаалгаас бусад) үйлчилгээ, засварын ажилдаа техникийн үзүүлэлт,

замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгөх ба баталгааг дагалдах хуудсаар баримтжуулна.

3.5.Баталгаат хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаанаас доошгүй байх бөгөөд хэрэв үйлдвэрлэгчээс хугацаа тогтоогоогүй бол баталгаат хугацаа нь 6 сараас доошгүй байна.

3.6.Техникийн үйлчилгээ, засварын байгууллагын, эрх, үүрэг

3.6.1.техникийн үйлчилгээ, засварын үнэ тарифыг тогтоох;

3.6.2.аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулан мөрдүүлэх;

3.6.3.үйлчилгээндээ баталгаат хугацаа тогтоох;

3.6.4.үйлчилгээ үзүүлэхдээ тээврийн хэрэгслийг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай бүртгэл хөтлөх ба хүлээн авсан тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцна;

3.6.5.засвар үйлчилгээний мэдээллийг тухай бүрт нь мэдээллийн санд тэмдэглэнэ;

3.6.6.баталгаат хугацаанд техникийн үйлчилгээ, засварыг хэрэглэгчид үзүүлэх;

3.6.7.үйлчилгээндээ үндэслэлтэй тогтоосон үнэ тарифыг мөрдөх;

3.6.8.үйлчилгээ, засвар хийсэн тээврийн хэрэгслийг үйлчлүүлэгчид техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагаатай эсэхийг нь шалгаж хүлээлгэн өгөх;

3.6.9.өөрийн үйлчилгээний төвийн байршил, цагийн хуваарь зэрэг мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

3.6.10.засвар үйлчилгээ хийлгэх захиалгыг цахим сүлжээгээр хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх.

3.7.Техникийн болон засварын үйлчилгээ эрхлэх байгууллагад хориглох зүйл

3.7.1.гарал үүслийн гэрчилгээгүй, үйлдвэрлэгчээс тогтоосон баталгаат болон хадгалах хугацаа дууссан, мөн чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнээр үйлчлэх;

3.7.2.хэрэглэгчийг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, үндэслэлгүй тогтоосон үнэ тариф мөрдөх;

3.7.3.хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулах, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах аюултай бодис, технологийг зөвшөөрөлгүйгээр ашиглах;

3.7.4.техникийн үйлчилгээ, засварт хүлээн авсан тээврийн хэрэгслийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр жолоодож замын хөдөлгөөнд оролцох, бусад байдлаар ашиглах;

3.7.5.зохих журмын дагуу тохирлын үнэлгээнд хамрагдаагүй, эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгохгүйгээр үйлчилгээ эрхлэх.

Дөрөв. Ашиглалтын материалаар хангах үйл ажиллагаа

4.1.Ашиглалтын материалаар хангах үйлчилгээнд тээврийн хэрэгсэл, түүний сэлбэг, тоног төхөөрөмж худалдаалах, түүгээр үйлчлэх, шатахуун тосолгооны болон ашиглалтын бусад материалаар (цаашид “бараа, бүтээгдэхүүн” гэх) хангах зэрэг үйлчилгээ хамаарна.

4.2.Ашиглалтын материалаар хангах байгууллагын үүрэг.

4.2.1.нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт шаардлагад нийцэж байгаад баталгаа гаргаж өгөх ба баталгааг дагалдах хуудсаар баримтжуулна;

4.2.2.баталгаат хугацаа нь үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаанаас доошгүй байх бөгөөд баталгаат хугацаанд техникийн бүрэн байдалтай холбоотой үйлчилгээг хариуцна;

4.2.3.хэрэв үйлдвэрлэгч удаан хугацаанд хэрэглэх бараанд баталгаат хугацаа тогтоогоогүй бол барааг үйлчлүүлэгчид нийлүүлсэн өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд барааны чанар, аюулгүй байдлын баталгаа гаргана;

4.2.4.нийлүүлсэн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх заавар, хадгалах, ашиглахад дагаж мөрдөх зааварчилгаа болон бусад мэдээллийг хэрэглэгчид үнэн зөв өгөх;

4.2.5.тээврийн хэрэгсэл нийлүүлсэн иргэн аж ахуйн нэгж байгууллага нь ашиглалтын хугацаанд найдвартай ажиллагааг хангах

зорилгоор техникийн үйлчилгээг зохион байгуулах, түүнчлэн үйлдвэрлэлийн хугацаанд болон түүнийг үйлдвэрлэлээс хассанаас хойш ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд, хэрэв ийм хугацаа заагаагүй бол худалдаанд нийлүүлснээс хойш 5 хүртэл жилийн хугацаанд холбогдох сэлбэг хэрэгслийг худалдаанд нийлүүлж байх.

4.3.Ашиглалтын материалаар хангах байгууллагад хориглох зүйл.

4.3.1.гарал үүслийн гэрчилгээгүй, үйлдвэрлэгчээс тогтоосон баталгаат болон хадгалах хугацаа дууссан, мөн чанарын шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх;

4.3.2.хууран мэхлэх аргаар бараа, бүтээгдэхүүн борлуулан хэрэглэгчийг хохироох.

4.3.3.зохих журмын дагуу тохирлын үнэлгээнд хамрагдаагүй, эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгоогүйгээр үйлчилгээ эрхлэх.

Тав. Тээврийн хэрэгслийн хадгалалтын үйлчилгээ

5.1.Тээврийн хэрэгслийн хадгалалтын үйлчилгээнд тээврийн хэрэгслийг урт, богино хугацаагаар хадгалах авто зогсоол, түүнтэй нийцсэн бусад үйлчилгээг төлбөртэйгөөр үзүүлэхэд хамаарна.

5.2.Тээврийн хэрэгслийн хадгалалтын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын үүрэг.

5.3.авто зогсоол нь “Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342:2007 стандартын шаардлагад бүрэн нийцсэн байх;

5.3.1.тээврийнхэрэгслийг хадгалалтад хүлээн авах, хүлээлгэн өгсөн тухай цахим бүртгэл хөтлөх;

5.3.2.тээврийн хэрэгслийг хүлээн авснаас хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд тухай тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;

5.3.3.авто зогсоолын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцах;

5.3.4.аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулан мөрдөх;

5.3.5.Тээврийн хэрэгслийн хадгалалтын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад хориглох зүйл;

5.3.6.зогсоолын тоо, үйлчилгээний хүчин чадлаас илүү тээврийн хэрэгсэл хүлээн авах;

5.3.7.хадгалалтад хүлээн авсан тээврийн хэрэгслийг жолоодож замын хөдөлгөөнд оролцох, бусад байдлаар ашиглах.

Зургаа. Тохирлын үнэлгээ хийх үйл ажиллагаа

6.1.Тохирлын үнэлгээг “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуульд заасны дагуу Стандартчиллын төв байгууллагаас итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага гүйцэтгэнэ.

6.2.Тохирлын үнэлгээг “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 17 дугаар зүйлд заасан “Техникийн хяналт”-ын төрлөөр хийнэ.

6.3.“Техникийн хяналт”-ыг “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хүрээнд хийнэ.

6.4.Авто үйлчилгээний байгууллага нь тохирлын үнэлгээнд хамрагдах хүсэлтээ мэдээллийн сан дах батлагдсан маягтын дагуу тохирлын үнэлгээний байгууллагад гаргана.

6.5.Тохирлын үнэлгээний байгууллага нь тохирлын үнэлгээнд хамрагдах хүсэлтийг хүлээн авснаар ажлын 5 хоногийн дотор шинжээчийн дүгнэлт гаргана.

6.7.Техникийн хяналтын шинжээч нь автотээврийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, бакалавраас доошгүй зэрэгтэй, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, эсвэл зөвлөх инженерийн зэрэгтэй, тохирлын үнэлгээний чиглэлээр мэргэшсэн байна.

Долоо. Авто үйлчилгээний мэдээллийн сан

7.1.“Авто үйлчилгээний мэдээллийн сан” нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн төрөлжсөн бусад сантай холбогдон ажилладаг, мэдээлэл солилцдог байна.

7.2.Мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон зааврыг зохих байгууллагуудтай зөвшилцөн ангилал тогтоох эрх бүхий байгууллага боловсруулан хэрэгжүүлнэ.

7.3.Мэдээллийн санд тохирлын үнэлгээ хийх, ангилал тогтоох, засвар үйлчилгээний болон ашиглалтын бусад мэдээлэл хамаарна.

7.4.Ашиглалтын бусад мэдээлэлд тухайн тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд холбогдсон зам тээврийн осол, гал түймэр, байгалийн гамшиг, техникийн хяналтын үзлэг, даатгал болон марк, зориулалт өөрчилсөн мэдээлэл хамаарна.

7.5.Энэхүү журмын 7.4-т заасан мэдээллийг тухайн асуудлыг хариуцсан эрх бүхий байгууллагууд тухай бүрд нь оруулах ба тэдгээр мэдээллийн сангуудтай холбогдсон байна.

7.6.Мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, түүнийг хөгжүүлэх асуудлыг авто үйлчилгээний ангилал тогтоох эрх бүхий байгууллага хариуцна.

7.7.Тохирлын үнэлгээнд хамрагдах, ангилал тогтоолгох хүсэлт, түүнийг шийдвэрлэсэн тухай мэдэгдлийг мэдээллийн сангийн программ хангамжаар дамжин хийгдэнэ.

7.8.Мэдээллийн сангийн засвар үйлчилгээний хэсэгт оруулсан мэдээллийг өөрчлөх эрх зөвхөн мэдээллийн сангийн эрх бүхий тушаалтанд байна.

Найм. ХАРИУЦЛАГА

8.1.Авто үйлчилгээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Патентын тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль” болон холбогдох бусад хууль, эрх зүйн баримт бичгийг мөрдөн шийдвэрлэнэ.

8.2.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.3.Авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх нь зөвхөн хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтанд хамаарна.

8.4.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

---o0o---

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Засгийн газрын 2011 оны
311 дүгээр тогтоол

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү нийтлэг журмын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн хяналт шалгалтад хамрагдах өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага (цаашид "аж ахуйн нэгж, байгууллага" гэх) энэхүү нийтлэг журмыг дагаж мөрдөнө.

1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.

1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө.

1.6. Аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

1.7. Хуульд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ (мониторинг) хийхэд энэхүү нийтлэг журам хамаарахгүй.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

2.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2.2. Дотоод хяналт шалгалтын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомж,

Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

2.3. Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.

Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх үүрэг

3.1. Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ.

3.2. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна.

3.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

3.5. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ.

3.6. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

3.7. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна:

3.7.1. зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах;

3.7.2. хяналт шалгалт явуулахдаа аж ахуйн нэгж, байгууллагын салбар, нэгжийн удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

3.7.3. илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

3.7.4. шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.7.5. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

3.7.6. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.7.7. холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах;

3.7.8. дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах;

3.7.9. байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

3.7.10. хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.7.11. дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх.

3.8. Энэ журмын 3.7-д зааснаас бусад эрх, үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д тусгана.

3.9. Энэхүү журмын 3.7-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

4.1. Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна:

4.1.1. хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалт;

4.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд хийх хяналт шалгалт;

4.1.3. үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарт тавих хяналт шалгалт;

4.1.4. хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт;

4.1.5. өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;

4.1.6. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д тухайлан заасан бусад хяналт шалгалт.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан чиглэлээр дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах хэлбэрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-аар зохицуулна.

Тав. Хариуцлага

5.1. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

5.2. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

---oOo---

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 01 дугаар сарын
17-ний өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж, хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөнө.

Хоёр. Нэр томъёоны ойлголт

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. "Бөөний худалдаа" гэж хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай барааг жижиглэн худалдаа эрхлэгч этгээдэд их хэмжээгээр худалдах үйл ажиллагааг;

2.1.2. "Жижиглэн худалдаа" гэж хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан барааг худалдах үйл ажиллагааг;

2.1.3. "Худалдааны газар" гэж худалдаа хийх зориулалттай стандартын шаардлага хангасан суурин байгууламжийг;

2.1.4. "Худалдаа эрхлэгч" гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран зах зээлд бараа үйлчилгээг тогтвортой эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэнийг;

2.1.5. "Худалдагч" гэж худалдаа эрхлэгчийн бараа, үйлчилгээг хэрэглэгчид гардан хүргэх үйл ажиллагааг;

Гурав. Үйлчилгээний төрөл, хэлбэр

3.4. Авто үйлчилгээний хэлбэр:

3.4.1. Автотехникийн засвар үйлчилгээ;

3.4.2. Авто машин угаалга;

3.4.3. Авто машин зогсоол;

3.4.4. Тос, тосолгооны материалын худалдаа; 3.5. Бусад /гудамжны жижиг худалдаа/

Дөрөв. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг чиг үүрэг

4.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, нийслэлийн нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлнэ.

4.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нь ажлын байрны нөхцөл, аюулгүй байдал, тухайн үйлчилгээний стандартын шаардлагыг хангасан талаар эрх бүхий байгууллагаас хуулийн хүрээнд дүгнэлт гаргуулж, Дүүргийн Засаг даргын дэргэдэх "Зөвлөл" –тэй үйл ажиллагааны гэрээ байгуулан, худалдаа, үйлчилгээний

мэдээллийн санд бүртгүүлсний дараа худалдаа, үйлчилгээ эрхэлж, холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үйл ажиллагаа явуулна.

4.6. Аж ахуйн нэгжүүд нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг зохион байгуулах нийтлэг журам”-д нийцүүлэн дотоодын хяналтыг тавьж хэрэгжүүлэх дотоод хяналтын нэгж, ажилтантай байна.

4.7. Худалдаа, үйлчилгээний газар нь гадна болон дотоод орчны аюулгүй байдлыг хангах хяналтын сүлжээнд холбогдон, дүүргийн Цагдаагийн хэлтэстэй гэрээ байгуулж, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана.

4.9. Худалдаа, үйлчилгээний гадна хаяг нь хотын өнгө төрх, дизайны шийдэлд нийцсэн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлтэй, стандартын шаардлагад нийцсэн агуулга бүхий хаяг цагийн хуваарийг монгол хэл дээр, кирилл үсгээр бичиж, ил тод харагдахуйц газар байршуулсан байна.

4.10. Худалдаа, үйлчилгээний газрын ажиллагсад нь ажлын онцлогт нийцсэн дүрэмт хувцас өмсөх ба ажилтаны овог, нэр, ажлын ур чадварын зэрэг дэвийг тодорхойлж бичсэн энгэрийн тэмдэг зүүх бөгөөд шаардлагатай ажлын байранд эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байна.

4.11. Цахилгаан техникийн бараа, гэрэл зургийн хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, тавилга, цаг үнэт эдлэл зэрэг баталгаат засварын үйлчилгээ шаарддаг барааг худалдаалдаг газрууд нь баталгаат засварын үйлчилгээний дагалдах хуудас болон тооцооны чекийг барааны хамт хэрэглэгчдэд дагалдуулж өгч байх үүрэгтэй.

4.12. Худалдаа, үйлчилгээний газрууд нь салбарт мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн болон нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын талаар байгууллагын ажилтнуудад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч сургалтыг жилд 1-2 удаа зохион байгуулна.

4.14. Худалдаа, үйлчилгээний газрууд нь иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, зөвлөгөө өгдөг, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажилтантай байх ба ажилтны нэр, холбоо барих утсыг ил тод байршуулсан байна.

4.18. Худалдаа, үйлчилгээ болон эрүүл мэндийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нь өөрийн бие засах газраар /ариун цэврийн өрөө/ иргэд, үйлчлүүлэгчдэд үнэ төлбөргүй үйлчилнэ.

4.19. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Тав. Тусгайлан хүлээх үүрэг

5.3. Авто засвар, машин угаалга, тос тосолгооны материалын худалдаа

5.3.1. Авто засвар, машин угаалга, шатах тослох материал, автомашин болон түүний сэлбэг хэрэгслийг худалдаалах иргэн, аж ахуйн нэгжүүд өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, нийслэлийн нутаг дэвсгэрт нийтээрээ дагаж мөрдөх дүрэм, журам, төр захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлж, хотын байгаль орчин, тохижилт, соёлжилтод онцгой анхаарч, ажиллана.

5.3.2. Ажлын байрандаа холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаар дүгнэлт, шинжилгээ хийлгэн баталгаажуулж тухайн дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх “Зөвлөл”-ийн даргатай гэрээ байгуулан ажиллана.

5.3.3. Авто үйлчилгээний барилга байгууламжийн агааржуулалт, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байхаас гадна мэргэжлийн байгууллагаар шалгуулж, баталгаажуулсан байна

5.3.4. Авто машиныг угаах ажил үйлчилгээнээс гарч байгаа бохир усыг тунгааж, цэвэрлэж зайлуулах /нефтьийн бүтээгдэхүүн болон бусад хорт бодисоор бохирдсон усыг татуургын системд оруулахдаа зориулалтын шүүлтүүр бүхий төхөөрөмжөөр цэвэрлэнэ/ тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

5.3.5. Авто үйлчилгээний газар нь технологийн карт болон ажил үйлчилгээнд үндэслэлтэй тогтоосон үнийн тарифыг ил тод нийтэд харагдахуйц газарт байрлуулсан байна

5.3.6. Авто сэлбэг, засвар, худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь үйлчлүүлэгчид үзүүлсэн ажил үйлчилгээндээ тохирсон хугацаанд баталгаа гаргадаг байна.

5.3.7.Авто зогсоолын үйлчилгээ эрхлэгч нь галын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, аюул тохиолдсон үед авран хамгаалах, галын дохиолол, гал унтраах материал, багаж техник хэрэгслээр хангагдсан байна.

5.3.8.Авто зогсоолд тээврийн хэрэгслийг байрлуулахдаа заавал бүртгэл хөтөлж ажил хүлээлцэнэ.

Зургаа.Хориглох заалт

6.1.Хадгалах хугацаа дууссан, чанарын баталгаагүй бараа бүтээгдэхүүн худалдаалахыг хориглоно.

6.10.Үйлчилгээний стандартгүй ажил, үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

6.14.Барилгын суурийн давхарт шингэрүүлсэн шатдаг хий, хийн тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг ашиглах, хадгалах, худалдаалахыг хориглоно.

6.19.Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд ил задгай автомашиныг угаах, засварлах, хийн болон цахилгаан гагнуур хийх, шатах тослох материалын худалдаа үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

Арав.Хариуцлага

10.1.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2.Үйл ажиллагаандаа үйлчилгээний соёл, зан харьцааны доголдол гаргаж хэрэглэгчийг хохироосон нь тогтоогдвол тухайн аж ахуйн нэгжийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, сэрэмжлүүлэх арга хэмжээг авна.

10.3.Холбогдох хууль тогтоомж, стандарт, энэхүү журмын заалтуудыг давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үйл ажиллагааг зах зээлд зарлах, бүрэн зогсоох арга хэмжээ авна.

10.4.Үйл ажиллагааг нь бүрмөсөн зогсоосон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн талаар хэвлэл мэдээллээр сурталчлан сэрэмжлүүлнэ.

---o0o---

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Засгийн газрын 2018 оны 40 дүгээр
тогтоолын хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь гамшгийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох стандарт, техникийн норматив, дүрэм, журам, заавар, дэглэмийн биелэлтийг хангуулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах улсын хяналтыг төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хэрэгжүүлнэ.

Хоёр. Гамшгаас хамгаалах улсын хяналтын зохион байгуулалт

2.1. Гамшгаас хамгаалах улсын хяналтыг гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, байцаагч (цаашид нийтэд нь “улсын хяналтын байцаагч” гэх) хэрэгжүүлнэ.

Гурав. Гамшгаас хамгаалах улсын хяналтын чиглэл

3.1. Гамшгаас хамгаалах улсын хяналтыг дараах чиглэлээр зохион байгуулна:

3.1.1. гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийн биелэлт;

3.1.2. гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт;

3.1.3. төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, санхүүжилт, зарцуулалт;

3.1.4. улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах сургалт, бэлтгэл, бэлэн байдал;

3.1.5. гамшгаас хамгаалах зориулалттай хоргодох, түр амьдрах байр, цугларах талбай, нисдэг тэрэгний зогсоолын тоноглол, ашиглалтын байдал;

3.1.6. гамшгаас хамгаалах зориулалттай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ашиглалт, хадгалалтын байдал;

3.1.7. гамшгийн аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах бэлтгэл, бэлэн байдал;

3.1.8. хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаа, хязгаарлалтын болон хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт;

3.1.9. Засгийн газар, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын төв, орон нутаг дахь хуваарилалт, зарцуулалт;

3.1.10. гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэлт, нөхөн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын байдал.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү дүрмийг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----o0o-----

ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Засгийн газрын 2016 оны 48 дугаар
тогтоолын хавсралт

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гал түймрийн улсын хяналтын зорилго нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Барилгын тухай хууль болон тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас тогтоосон галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичгийн биелэлтийг хангуулахад оршино.

1.2. Гал түймрийн улсын хяналтыг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд гал түймрийн аюул, эрсдэл үүсгэхээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, заавал мөрдөх техникийн зохицуулалтад заасан шаардлагыг сахин биелүүлэх, хэрэглэгчид зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.9. Аж ахуйн нэгж, байгууллага Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.2-т заасны дагуу хяналтын байцаагч гэрээгээр ажиллуулж болно. Энэ тохиолдолд хяналтын байцаагч нь зөвхөн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хүрээнд гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Гал түймрийн улсын хяналт явуулах чиглэл

2.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гал түймрийн улсын хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

2.1.1. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, санамж, сэрэмжлүүлэг өгч, галын аюулгүй байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх;

2.1.2. Галын аюулгүй байдлын тухай, Барилгын тухай, Ойн тухай хууль, галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.3. гал түймэртэй тэмцэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, төсвийн төлөвлөлт, тоног төхөөрөмж, гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн хангалт, ашиглалт, хадгалалтын байдалд хяналт тавих;

2.1.5. гал түймрийн аюулгүй байдлыг хангах талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эрх бүхий албан тушаалтны хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, үнэлгээ өгөх, хэрэгжилтийг хангуулах;

2.1.6. хот, суурины төлөвлөлт, барилга байгууламжийн байршлыг тогтоох, объектыг гал түймрийн аюулаас хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанд мэргэжлийн дүгнэлт гаргах;

2.1.8. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад объектын болон ой, хээрийн түймэр гарсан үед шуурхай мэдээлэх, унтраах бэлтгэл, гал

түймрээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, учирч болох хохирлыг багасгахад чиглэсэн арга хэмжээг урьдчилан авсан эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.10.барилга байгууламж болон үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжид хийсэн гал түймрийн аюулын үнэлгээний чанарт хяналт тавих.

Гурав. Хяналтын байцаагчийн бүрэн эрх

3.1. Хяналтын байцаагч дараах эрхтэй байна:

3.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гал түймрийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон баримт бичиг, мэдээ, материалыг үнэ төлбөргүй гаргуулж авах;

3.1.4.гал түймрийн тухай мэдээлэх, ой, хээрийн болон объектын гал түймрийг унтраах, хойшлуулшгүй арга хэмжээ авах зорилгоор өмчийн хэлбэр харгалзахгүйгээр холбооны хэрэгслийг үнэ төлбөргүй, дараалал харгалзахгүй түр ашиглах;

3.1.5. галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийг ноцтой зөрчсөний улмаас гал түймэр гарах бодит аюул бүрдсэн, гал түймэр гарсан тохиолдолд хүний амь насанд шууд аюул учрахаар нөхцөл бий болсон гэж үзвэл иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж ашиглахыг бүхэлд нь буюу хэсэгчилэн түр зогсоох;

3.1.6. гал түймэр унтраах зорилгоор ашигладаг гал эсэргүүцэх усан хангамж (усны шугам сүлжээ, худаг, усан сан)-ийг байнгын ажиллагаатай байлгахыг холбогдох байгууллагаас шаардах, биелэлтэд нь хяналт тавих;

3.1.7.Галын аюулгүй байдлын тухай хууль, норм, нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөн, гал түймэр тавьсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх;

3.1.8. хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг, даалгавар өгөн, биелэлтийг хангуулах;

3.1.9. галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн хэрэг, зөрчлийг шалгах болон галын галын аюулгүй байдлын хяналт, шалгалтаар явах үед хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгслээр нөхөн олговортойгоор зорчих.

3.2. Хяналтын байцаагч дараах үүрэгтэй байна:

3.2.1.энэ дүрмийн 2-т заасан чиглэлийн дагуу гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлж ажиллах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламжийн галын аюулгүйн байдлыг шалган, илэрсэн зөрчлийг арилгуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.2.3.гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуур, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх, тэдгээрийн үүрэг, зориулалт, төрөл, хүчин чадал, ашиглах, хадгалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажилтнуудад мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөө өгөх;

3.2.4.гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр гарын авлага, сэрэмжлүүлэг, зөвлөмж, материал боловсруулах, бэлтгэх, тэдгээрийг хяналт шалгалтын үед тайлбарлан таниулах, тараах, сурталчилах арга хэмжээ авах;

Дөрөв. Бусад зүйл

4.1. Хяналтын байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Ойн тухай, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шийтгэл ногдуулна.

4.2. Зөрчил гаргасан этгээд түүнд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд төлж барагдуулна.

4.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хяналтын байцаагч хууль тогтоомж зөрчсөн, байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллага, эсхүл Ерөнхий байцаагчид шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан гаргана. Гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэж, хариу өгнө. Хэрэв энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

СТАНДАРТУУДЫН ЖАГСААЛТ

№	Стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ, он
1	Техникийн оношлол. Үндсэн нэр томъёо, тодорхойлолт	MNS 3814:1985
2	Техникийн үйлчилгээ, засварын систем нэр томъёо, тодорхойлолт	MNS 3850:1985
3	Техникийн найдварт ажиллагаа, түүний нормчлогдох үзүүлэлтүүдийг шалгах тодорхойлох арга. Ерөнхий шаардлага.	MNS 3990:1987
4	Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага	MNS 4598:2011
5	Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд	MNS 4599:2003
6	Авто үйлчилгээ-Ангилал.Ерөнхий шаардлага	MNS 5025:2010
7	Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт	MNS 4601:2011
8	Автомашин угаалгын үйлчилгээ-Ангилал.Ерөнхий шаардлага	MNS 5347:2003
9	Замын тээврийн хэрэгслийн ерөнхий асуудал. Автотээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд.Ангилал.Ерөнхий шаардлага	MNS 4470:2005
10	Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин.Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5013:2009
11	Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5014:2009
12	Авто зогсоол.Ангилал ба ерөнхий шаардлага	MNS 5342:2007
13	Автотээврийн үйлчилгээ. Зорчигч тээврийн автобуудал	MNS 6300:2011
14	Автотээврийн салбарын ажил мэргэжлийн стандарт.Ерөнхий шаардлага	MNS 6595:2016
15	Нийтийн тээвэр. Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага	MNS 5879:2012
16	Хүнд даацын автотээврийн хэрэгсэл. Техникийн ерөнхий шаардлага	MNS 6278:2011
17	Автотээврийн хэрэгсэл. Масс. Тайлбар толь ба код	MNS ISO 1176:2001

18	Автотээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшний нэмэлт төхөөрөмжөөр тоноглох үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага	MNS 5529:2005
19	Ачааны машин ба чиргүүлийн хэрэгсэл. Суудлын автомашины чиргүүл САЧ-500 техникийн шаардлага.	MNS 5394:2004
20	Автотээврийн хэрэгсэл. Механикжсан тээврийн хэрэгслийн оношлогооны систем. Тайлбар толь	MNS ISO 4092:2001
21	Машин механизмын бүхээг доторх дуу чимээ түвшинг тодорхойлох	MNS ISO 5128:2005
22	Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566:2005
23	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага	MNS4968:2000
24	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага	MNS4930:2000

НОРМ, НОРМАТИВЫН ЖАГСААЛТ

№	Нэр	Дугаар
1	- Автомашин эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, - Автомашин резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм, - Автомашин зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг норм, - Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм	Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал
3	Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт дүрэм	Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 33 дугаар тушаал
4	Барилга байгууламжийн галын аюулгүй байдал	БНБД 21-01-02

5	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм	БНБД 21-02-02
6	Авто зогсоол	БНБД 21-05-10
7	Цахилгаан техникийн ажил	БНБД 3.05.06.90
8	Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтийн норм ба дүрэм	БНБД 30-01-04
9	Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл	БНБД 21-04-05
10	Барилгын доторхи ус хангамж, ариутгах татуурга	БНБД 40-05-16
11	Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар	БД 43-101-04
12	Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж	БНБД 40-02-16
13	Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер	БНБД 41-01-11

Иргэн, аж ахуйн нэгжийн баримт бичгийн жагсаалт

Ажил олгогч, байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн дүрэм, журам, заавар зэрэг зохион байгуулалтын баримт бичиг, тогтоол, тушаал, захирамж зэрэг захирамжлалын баримт бичиг баталж, гаргана.

№	Нэрс	Үндэслэл
1	Хөдөлмөрийн дотоод журам	Хөдөлмөрийн тухай хуулийн 130.1
2	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол 1.3
3	Ажлын байрны онцлогт тохирсон эрүүл ахуйн дүрэм, заавар, журам	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.6
4	Дотоод хяналт шалгалт хийх удирдамж, төлөвлөгөө, тайлан	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 3.6, 3.7.1
5	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр, төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалт	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1, 15.3

6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, тайлан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3.1
7	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.4
8	Аюул ослыг илрүүлэх хуудас	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.2
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны зааварчилгаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18.2.2, 28.1.8
10	Тоног төхөөрөмж, өргөх механизмийн аюулгүй ажиллагааны заавар	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.1.2
11	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1, 9.1.1
12	Аюул, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө	Хог хаягдлын тухай хуулийн 26.1.1
13	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1, 34.2.1
14	Галын аюулгүй байдлын дүрэм	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10
15	Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө	
16	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө(орон нутгийн онцгой байдлын газраар батлуулах)	Хог хаягдлын тухай хуулийн 4.1.44, 26.1.5
17	Тухайн жилд үйлчлүүлсэн хэрэглэгчдийн талаарх судалгаа, мэдээ	Автотээврийн тухай хуулийн 19 ² .3.2
18	Аюултай хог хаягдлын мэдээ, тайлан	Хог хаягдлын тухай хуулийн 11.3
19	Технологийн карт	MNS 4601:2011 стандартын 4.5
Томилон ажиллуулах шаардлагатай ажилтан		
1	Автотээврийн салбарын дээд боловсролтой механик инженер /мэргэшсэн/	MNS 5025:2010 стандартын 11.1

2	Дотоод хяналт шалгалтын ажилтан	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 3.2, Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журмын 4.6
3	Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан	Хог хаягдлын тухай хуулийн 23.7
4	Онцгой байдлын зохицуулагч	Хог хаягдлын тухай хуулийн 4.1.45
5	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох орон тооны бус байнгын комисс	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29.2
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.2

Авто үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээлэл авах цахим хаягууд:

1. Зам, тээврийн хөгжлийн яам- 51263168, www.mrtd.gov.mn
2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар-18001286, www.inspection.gov.mn /Хяналт шалгалт-Хяналтын хуудас-5.33 Авто тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас/
3. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар- 70128012, www.ub.inspection.gov.mn /Хяналт шалгалтын төлөвлөгөө/
4. Авто үйлчилгээний мэдээллийн сан- www.autobox.mn
5. Шилэн хяналтын цахим хуудас- www.shilenhyanal.gov.mn
6. Байгаль орчин, аялал жуучлалын яам-51261966, www.mne.mn
7. Онцгой байдлын ерөнхий газар- 325726, www.nema.gov.mn
8. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам-51261553, www.mlsp.gov.mn /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр/

9. Нийслэлийн тээврийн газар- 326352, www.transport.ub.gov.mn
10. Эрх зүйн мэдээллийн систем- www.legalinfo.mn
 - Засгийн газрын 2005 оны 127 дугаар тогтоол-Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт;
 - Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал- Автомашин шатахуун зарцуулалтын жишиг норм; Автомашин, түүний резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм;
 - Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаал- Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар;
 - Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоол- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм;
 - Хөдөлмөрийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/295 тоот тушаал- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж;
 - Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаал- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай.
11. Стандарт, хэмжилзүйн газар- www.estandard.gov.mn
12. Харьяа аймаг, дүүргийн засаг даргын тамгын газар
13. Автотээврийн үндэсний төв-19001234, 70070021, www.transdep.mn
14. Гадаадын иргэн, харьяатын газар-18001882, www.immigration.gov.mn
15. Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо ТББ-70116345, www.recycling.mn
16. Монголын Хуульчдын холбоо- 70116007, www.mglbar.mn

---o0o---